

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-14
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	15-56
<hr/>	
1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэв/	15-34
2.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	34-35
3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-т заасны дагуу/	36-39
4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	39-56

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 01-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 76 гишүүн хүрэлцэн ирж, 60.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Э.Бат-Амгалан, П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Ц.Туваан, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Ө.Шижир;

Чөлөөтэй: Э.Батиугар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Б.Батбаатар, Б.Батцэцэг, Х.Болормаа, Ж.Ганбаатар, З.Мэндсайхан, Б.Пунсалмаа, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Х.Тэмүүжин;

Хоцорсон: Н.Алтанишагай -1 цаг 17 минут, Х.Баттулга -22 минут, Б.Бейсен -01 минут, Э.Болормаа -04 минут, А.Ганбаатар -03 минут, Г.Ганбаатар -07 минут, Д.Ганбат -13 минут, Л.Гантөмөр -23 минут, Б.Дэлгэрсайхан -26 минут, Б.Жаргалан -05 минут, Ж.Золжаргал -06 минут, С.Лүндэг -1 цаг 35 минут, Ц.Мөнхбат -2 цаг 02 минут, П.Мөнхтулга -1 цаг 04 минут, Ц.Мөнхтуяа -03 минут, А.Ундраа -07 минут, Л.Энх-Амгалан -11 минут, Ж.Энхбаяр -04 минут.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт,

шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах үг хэлж, өөрийн гаргасан, 24.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.137.Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 6,710.4 сая төгрөг, санхүүжих дүн 5,910.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 2,100.0 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 3,810.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг тус тус шинээр нэмэх гэсэн саналаа татан авах тул, 2024.10.31-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар 24 дүгээр зарчмын зөрүүтэй саналаар явуулсан санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 23
Бүгд: 90

74.4 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах 24 дүгээр зарчмын зөрүүтэй саналаа татан авав.

Д.Амарбаясгалан: 25.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 38
Бүгд: 92
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.178.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 2,100.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.31.Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 11,121.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,548.3 сая төгрөг гэсэн төсөл хэмжээний нэрийн “24

у/м” гэсний дараа “гэрэлтүүлэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 67
Бүгд: 92
27.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

27.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.185.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/, хэрэгжих хугацаа 2018-2025 он, төсөвт өртөг 2,160.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,300.0 сая төгрөгөөр бууруулж, Төрийн аудитын газрын байр худалдан авах /Сүхбаатар/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,300.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 55
Бүгд: 92
40.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

28.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.1.24.Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 15,758.5 сая төгрөг, санхүүжих дүн 6,488.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.41.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 3,000.0. сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний “Чандмань” гэсний дараа “Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 62
Бүгд: 92
32.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

29.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Урсгал зардлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангилалд тусгагдсан 1,857,913.3 сая төгрөгийг эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарт 30 хувиар бууруулах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Жавхлан, О.Алтангэрэл, Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 49

Бүгд: 95
48.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 42
Бүгд: 95
55.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 29.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Урсгал зардлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангилалд тусгагдсан 1,857,913.3 сая төгрөгийг эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарт 30 хувиар бууруулах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 40
Бүгд: 95
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйл буюу Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 3,500,000.0 сая төгрөг гэснийг 2,500,000.0 сая төгрөг гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 49
Бүгд: 95
48.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 32
Бүгд: 96

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 30.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйл буюу Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 3,500,000.0 сая төгрөг гэснийг 2,500,000.0 сая төгрөг гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 30

Бүгд: 96

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн урсгал зардалд туссан Зээлийн үйлчилгээний төлбөр 1,303,370.7 сая төгрөг гэснийг 1,263,370.7 сая төгрөг гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Т.Доржханд, Б.Жавхлан, Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 31

Бүгд: 96

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дэх Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын 5.1.5 Эрсдэлийн санд тусгагдсан 53,562.6 сая төгрөгөөр 5.1.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 90

Бүгд: 96

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

33.Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХХI.1.33.“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/, хэрэгжих хугацаа 2023-2026 он, төсөвт өртөг 135,583.3 сая төгрөг, санхүүжих дүн 34,278.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,900.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Улаан-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам 2.1 км /Увс, Улаангом сум, 5-р баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,400.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,400.0 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн автомашины зогсоол /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 34
Бүгд: 96
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан албан бичгээр өөрийн гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал”-ыг 9,278.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр XIX.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 9,278.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналаа татан авав.

35.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин үг хэлж, өөрийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 200 ор, /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 4,510.1 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналаа татан авав.

36.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,200.0 сая төгрөгөөр бууруулж, Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 13,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,500.0 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 5,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,700.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 34
Бүгд: 96
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 14,700.0 сая төгрөгөөр бууруулж, Үерийн хамгаалалтын далангийн засвар шинэчлэлт /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/, төсөвт өртөг 7,321.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг, Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам II үе шатны ажил /Дархан-Уул/, төсөвт өртөг 9,723.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул/, төсөвт өртөг 17,147.9 сая төгрөг, санхүүжих дүн 5,700.0 сая төгрөг, Өргөх насос станцын тоноглол /Дархан-Уул, Дархан сум/, төсөвт өртөг 8,535.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 27
Бүгд: 96
71.9 хувийн саналаар дэмжигдлээ.

38. Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.19. Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66км /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 163,736.3 сая төгрөг, санхүүжих дүн 32,747.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,957.9 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.70. Хар үзүүр, Ховд голын төмөр бетон гүүр, 217 у/м, хатуу хучилттай авто зам, 0.4 км /Баян-Өлгий, Алтанцөгц сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 8,913.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,706.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,957.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 38
Бүгд: 98
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Төсвийн байнгын хорооны дэмжсэн, Ажлын хэсгийн гаргасан, 2.3. Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.24. Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, XIX.1.9. “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй саналаар 2024.10.31-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулсан санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж тайлбар хийж, уг горимын саналаар санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлж, өөрийн гаргасан, 17. Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1. Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг болон санхүүжих дүн 5,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналаа татан авах тул, 2024.10.31-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар 17 дугаар зарчмын зөрүүтэй саналаар явуулсан санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 32
Бүгд: 98

67.3 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал 17 дугаар зарчмын зөрүүтэй саналаа татан авав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Ажлын хэсгийн гаргасан, 2.3.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.24.Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, XIX.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй саналаар 2024.10.31-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалт явуулахад “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул уг санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 30

Бүгд: 98

69.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гаргасан, 2.3.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.24.Оюутны дотуур байрны барилга /Ховд/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 12,606.8 сая төгрөг, санхүүжих дүн 5,803.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр бууруулж, XIX.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 30

Бүгд: 98

69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-т заасны дагуу тодорхой асуудлын хүрээнд дахин явуулахаар Хууль зүйн болон Төсвийн байнгын хороонд буцаав.

Уг асуудлыг 11 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 27
Бүгд: 98
72.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 27
Бүгд: 98
72.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 28
Бүгд: 98
71.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн, Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо хуралдах тул хуралдаан 11 цаг 33 минутад завсарлав.

Хуралдаан 14 цаг 46 минутаас үргэлжлэв.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14-т заасны дагуу/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.2, 71.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар танилцуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Да.Цогтбаатар, П.Сайнзориг нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, санхүүжих дүн 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 39,951.5

сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх. Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын XXV.3.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 15,275.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

-Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,801.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,120.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 4,452.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,780.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,320.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,928.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2013-2026 он, төсөвт өртөг 44,552.4 сая төгрөг, санхүүжих дүн 15,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 47
Бүгд: 99
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь заалтыг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар болон Сангийн яаманд үүрэг болгов.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, О.Батнайрамдал, Б.Түвшин, Ж.Баярмаа, Ц.Сандаг-Очир, Д.Батбаяр, Д.Энхтүвшин, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 50 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 01 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. 76 гишүүн ирж, 60,3 хувьтай ирц хүрсэн байна. Өнөөдрийн нэгдсэн хуралдааны чуулганыг эхлүүлэе. 24 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 4 асуудлыг хэлэлцэхээр байгаа. 1 дүгээрт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ. 2 дугаарт Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. 3 дугаарт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулна. 4 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэх асуудалдаа орёе. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Эдгээр, энэ хуулийн төсөлтэй холбоотой Төсвийн байнгын хорооноос дэмжээгүй зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна. Нийт 14 санал үлдсэн байна. Гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. Гишүүд, Байнгын хороо тайлбар хийнэ.

25 дугаар санал дээр явж байгаа. Араас нь, ингээд санал хураалт явагдаж байна. Батсуурь гишүүн горимын санал.

Ж.Батсуурь: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналын 17-д өчигдөр будилсан уу яасан энэ Золжаргал гишүүний саналаар бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээний дэд бүтцээс 5 тэрбумыг бууруулж, цахим шилжилтэд 5 тэрбум гэж ийм алдаатай санал хурааж, энэ салбар хоорондын төсвийн баланс алдагдаж байгаа юм. Тэгэхдээ энийг яг энэ юутай 24 дэх заалттай адилхан ийм зарчимгүй зүйл болж ирж байгаа юм. Тэгээд Золжаргал гишүүн ирээгүй учраас би хугацааг нь өнгөрөөхөөс өмнө горимын санал гаргаж, энэ асуудлыг ахиж авч хэлэлцэхгүй бол болохгүй болчихоод байгаа юм.

Д.Амарбаясгалан: Золжаргал гишүүн ирнэ биз дээ. Энэ санал хураалтыг дуустал дараачийн санал хураалт явагдаж байх хооронд энэ Батсуурь сайдын саяын ярьсан горимын саналтай холбоотой асуудлыг ярилцъя. Ер нь бол яах вэ өчигдөр бас бүгдээрээ ярилаа шүү дээ. Мэргэжлийн Байнгын хороо, ажлын хэсэг ажиллаад төсвийн орчинтой холбоотой асуудлыг ярилцаад болох, болохгүйгээ Байнгын хороон дээрээ шийдэж орж ирээд дэмжинэ, дэмжихгүй гэдгээр санал хураалт явагдаж байгаа юм. Тэгэхээр яах вэ Улсын Их Хурлын хувьд мэргэжлийн Байнгын хорооноос орж ирсэн санал нь өөрөө зарим төрлийн дэмжээгүй санал нь төсөв хооронд зохицуулалт хийх боломжгүй эсхүл тодорхой хуулийн зөрчилтэй байна гэдэг агуулгуудын үндсэн дээр мэргэжлийн Байнгын хороо дэмжээгүй гэсэн шийдвэр гарч ирчхээд байгаа юм.

Гэтэл энийг нь Их Хурал дээр орж ирэхээр гишүүд зориуд кноподоо гар хүрэхгүй байх замаар унасан саналыг босгож байгаа энэ үйлдлүүд нь өөрөө хуулийн зөрчил үүсгэж байна гэдэг асуудал давхар яригдаж байна. Салбар хоорондын төсвийг Байнгын хороон дээр санал гаргангуутаа сайд нараас, ЗГ-аас байр суурийг сонсолгүйгээр бас хооронд нь гүйлгэж байгаа байдал ч гэсэн энэ асуудал үүсгээд байна гэдэг ийм байдал үүссэн. Өчигдөр бас Галбадрах гишүүн энэ 24 дүгээр санал дээр би өөрт чинь микрофон өгье, горимын санал гаргая гэсэн. Өчигдөр өөрөө байгаагүй. 1 дүүрэгт гүйцээн барих төсөвтэй явж байсан цэцэрлэгийн барилгын төсвийг татаж аваад, 2 дүүрэг дээр шинээр цэцэрлэг худалдаж авах төсөв болгоно гээд санал оруулчихсан байсан. Тэрийг чинь мэргэжлийн Байнгын хороо дэмжихгүй гэсэн саналтай байсан. Уг гишүүн маань өөрөө татах саналтай байж байгаад санал хураалтын үед байгаагүй. Тэрнээсээ болоод нөгөө санал нь Улсын Их Хурал дээр босоод ирчихсэн явж байгаа юм. Тэгэхээр иймэрхүү зөрчлийн асуудлууд байгаа учраас Улсын Их Хурлын гишүүд минь аливаа асуудалд зөв хандаж, энэ мэргэжлийн Байнгын хорооныхоо саналыг харгалзан үзэж, санал өгөхийг хүсэж байна. 24 дүгээр санал хураалттай холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн Галбадрах гишүүн горимын санал гаргана. Галбадрах гишүүний микрофоныг өгье.

Ж.Галбадрах: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өглөөний мэндийг хүргэе. Миний хувьд гишүүн аль ч шатанд саналаа эргэж татагдах ийм боломжтой гэсэн хуулийн дагуу зарчмын зөрүүтэй саналаа бол татаж авч байна. Сая Их Хурлын даргын хэлсэнчлэн мэргэжлийн Байнгын хороон дээр дэмжигдээгүй байсан саналаа чуулган дээр орж ирээд, түүн дээр татаж авна гэсэн. Тэгээд би албан ёсоор өчигдөр бас чөлөөтэй байсан юм байгаа юм. Тэгээд тэр чөлөөнийхөө дагуу ингээд саналаа хэлж чадсангүй.

Тэгэхдээ би бас үргэлжлээд энэ маань би өөрөө өчигдөр байж тайлбараа хийж чадаагүй учраас зарим хүнд буруу ойлголт явагдаад, лобби явж байна гэсэн юм яригдаж байна. Тэгэхээр би энэ дээр бас тайлбар тавья гэж бодож байна. ЧД-ийн 74 дүгээр цэцэрлэг гэж байгаа. Энэ цэцэрлэг 21 оноос хойш дараалан 4 удаа улсын төсөвт тавигдсан боловч тэр ингээд одоо байгаа цэцэрлэг юм байгаа юм. Нураагаад дахиж цэцэрлэг барина гэдэг. Тэгээд энэ нь 4 жил дараалан төсөвт тавигддаг боловч оршин суугчид эсэргүүцдэг. Нөгөө талаасаа тендерт компаниуд орж ирдэггүйн улмаас энэ 4 удаа орж ирээгүй ингээд яваад байгаа. Энэ жил бас тавигдаад ороод ирсэн байна.

Гэтэл өнөөдөр Энх-Амгалан сайдын үеэс бид нар сугалаагүй цэцэрлэгийн сугалааг алга болгоно гээд маш олон газар энэ түрээсээр явдаг. Энэ түрээсийн цэцэрлэгүүдээс бид нар хувийн цэцэрлэг болно, эсвэл түрээсээр явахгүй гэдэг энэ асуудлууд маш их олноор гарч ирж байгаа юм байна. Тэгээд би бол боловсролын салбар багш нарын төлөөллийн хувьд бол хэдэн хүүхдийн ч гэсэн асуудлыг шийдье гээд яг хүндрэлтэй байгаа тийм түрээсийн нөхцөлтэй цэцэрлэг дээр энэ төсөв хэрвээ тавигдаад баригдахгүй юм бол тэрийг шилжүүлэх боломж нь ямар байдаг юм бэ гэдгийг судалж үзсэн. Ингээд 30-аас доош

хувийн ирцтэй хамрагдаж байгаа БГД-ийн тэр Нарны хороолол, мөн Хан-Уул дүүрэгт байсан энэ 2 цэцэрлэг хоёулаа нэг цэцэрлэг нь бол 150 хүүхдийн хүчин чадалтай боловч 300 хүүхэд, 298 хүүхэд одоо явж байгаа. Нөгөө цэцэрлэг нь болохоор 200 хүүхдийн хүчин чадалтай боловч 420 хүүхэд ингээд 718 хүүхдийн асуудал ирэх долоо хоног, ирэх жилээс цэцэрлэггүй болох нь.

Энийг бид нар яаралтай худалдаж авах шаардлага байна гэдгийг би Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хүмүүстэй ярилцаад, би бас өөрөө хүүхэд цэцэрлэг, сургуульд явж байгаа хүүхдүүдэд боломж олгоё гээд. Энэ 718 хүүхдийн асуудлыг л бодож, энэ дээр маш их олон өргөдөл нь хэдэн жил дараалаад ирсэн байсныг нь судалж үзэж, би бол энэ төсвийн номоо бол эргэтэл нь, хуудсыг нь салтал уншиж, боловсролын төлөөллийн хувьд нэг ч сургууль, нэг ч цэцэрлэгийг төсвийг нь тавиулчих юм сан, хасуулахгүй байх юм сан гэдэг үүднээс ингэж санал тавьсан байсан юм. Түүнээс энд ямар ч лобби байж, миний эрх ашгийн зөрчилтэй юм бол байгаагүй гэдгийг хариуцлагатайгаар хэлж байна. Ингээд саналаа татаж авч байна.

Д.Амарбаясгалан: Тамгын газар санал хураачихсан саналыг татаж авахаар яах билээ. Хамаагүй шууд татсанаар авчихна тийм ээ. 24 дүгээр санал, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах татаж авлаа. Золжаргал гишүүн үг хэлэх юм уу? Тамгын газраас над руу мэдээлэл өгч байна. Санал хураагаад шийдвэрлэгдсэн санал учраас тэр хураасан саналыг хүчингүй болгож байж, татах эрх нь нээгдэнэ гэж байна. Тийм учраас 24 дүгээр санал Галбадрах гишүүний гаргасан санал байсан. Өөрийг нь байхгүйд өчигдөр санал хураагаад, үгүй ээ гол нь санал хураачихсан байхгүй юу өчигдөр. Биш ээ биш, энэ чинь өчигдөр санал хураагаад энд шийдэгдчихсэн зүйл байхгүй юу. Тийм. Тийм тэгэхээр санал хураана. Тэгэхээр горимын саналаар Галбадрах гишүүний гаргасан горимын саналаар 24 дүгээр санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулна. Санал хураалт. 74,4 хувиар, Даваасүрэн гишүүн Улсын Их Хурал дээр хураагдсан санал хүчингүй болж байгаа юм. Ингээд одоо энэ санал татагдах эрх боломжтой. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Галбадрахын гаргасан саналын дагуу 24 дүгээр саналыг татлаа.

25 дугаар санал. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын Соёлын эрхийн бичиг арга хэмжээний зардлыг 18,325.9 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. БСШУС-ын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Энэ олон гишүүд гар өргөөд байх юм, цуцалъя. Даваасүрэн гишүүн тайлбар хийе. Олон гишүүд гар өргөөд байгаа учраас санал хураалтын дүн гарахаас өмнө цуцалсан байгаа.

Ц.Даваасүрэн: Би зүгээр нэг тайлбар хийчихье гэж бодлоо. Энэ Тамгын газрынхан ч гэсэн анхаар. Аль ч шатанд татаж болно гэдэг чинь энэ санал дэмжигдсэн байсан ч татаж болно нөхөд өө. Тэрнээс үгүй ээ, одоо энэний чинь дараа гуравдугаар хэлэлцүүлгийн өмнө татчихаж болно. Тэрнээс биш, үгүй ээ үгүй заавал Байнгын хороонд ороод биш, Байнгын хороонд орохоос өмнө ч татаж болно. Аль ч шатанд татаж болно гээд хуульчилчихсан байхад чинь дураараа хууль тайлбарлаад байх юм. Энэ зүгээр л ингээд татагдаад л явчих ёстой юм байхгүй юу. Тэрнээс биш энийг ингээд л хүчингүй болгоод л, заавал хүчингүй болгож байж санал татдаг гэдэг тийм хуулийн буруу дэг рүү явчихлаа шүү дээ. Хүчингүй болгохгүй бол тэгээд татаж болдоггүй юм уу?

Д.Амарбаясгалан: Тамгын газар энэ дээр анхааръя. Тэгье. Даваасүрэн гишүүний хэлж байгааг сайн нягталж үз. 25 дахь санал хураалт. Сая төхөөрөмжүүд нь гацсан гишүүд төхөөрөмждөө хурууныхаа хээг уншуулаарай. Санал хураалт явуулъя. 58,7 хувиар санал

дэмжигдлээ. 26.Төслийн 2 дугаар хавсралтын ХИҮ.1.1.178.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 2,100.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр бууруулж, ХҮИ.1.1.31.Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 11,121.7 сая төгрөг, санхүүжих дүн 5,548.3 сая төгрөг гэсэн төсөл хэмжээний нэрийн “24 у/м” гэсний дараа “гэрэлтүүлэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 717.9 сая төгрөгөөр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор, Батсуурь гишүүн. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсуурь үг өгье.

Ж.Батсуурь: Гишүүддээ өглөөний мэндийг дахин хүргэе. Тэгэхээр Сүхбаатар аймгийн хэмжээнд 2 барилга л зарччихаад байгаа юм. 19 онд, 18 онд тендер нь зарлагдаад, тэгээд энийг Наранбаяр сайд бид 2 ярьж байгаад Дүйнхэржав гуай энэ тэрийг Техникийн их сургуулийн докторыг аваачаад, орон нутгаас юуг нь гаргаад мөнгийг нь гаргаад, дахин эксперт оруулахгүй бол болохгүй болчхоод байгаа юм. Тэгээд нэгэнт ийм тохиолдолд тавигдсан энэ мөнгө нь намар хураагдах учраас энэ мөнгийг ямар нэгэн бусад өөр юу руу биш үргэлжилж байгаа төсөлд нэмээд өгөөч гэсэн ийм санал байгаа юм. Тийм учраас Төсвийн хяналтын зарлагын дэд хороон дээр техникийн алдаа гараад бас дэмжигдээгүй юм. Тийм учраас энэ удаа дэмжихгүй байж өгнө үү гэж хүсэж байгаа юм. Тэгээд би цаг хэмнэх үүднээс 26, 27 дугаар саналыг дэмжихгүй байж өгнө үү гэж гишүүдээсээ хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга тайлбар байгаа юу? Төсөвт асуудалгүй, дотроо юу? 26 дугаар санал хураалт. Энэ тэгээд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 27,2 хувиар санал дэмжигдсэнгүй.

27.Төслийн 2 дугаар хавсралтын ХИҮ.1.1.185.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/, хэрэгжих хугацаа 2018-2025 он, төсөвт өртөг 2,160.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,300.0 сая төгрөгөөр бууруулж, Төрийн аудитын газрын байр худалдан авах, төсөвт өртөг болон санхүүжих дүн 1,300.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батсуурь. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Энэ, харин тийм. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 40,2 хувиар санал дэмжигдсэнгүй.

28.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮИ.1.1.24.Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 15,758.5 сая төгрөг, санхүүжих дүн 6,488.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, ХҮИ.1.1.41.Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 3,000.0. сая төгрөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний “Чандмань” гэсний дараа “Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг” гэж нэмж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 32,6 хувиар санал дэмжигдсэнгүй.

29. Урсгал зардлын бусдаар, Сайнзориг, Сайнзориг гишүүнээ, Батсуурь гишүүнээ чуулганы танхимд зүй бус үг хэллэг хэрэглэж хэрэлдэхгүй. Сануулах арга хэмжээ авна шүү. Үг хэлэх эрхийг чинь хаана шүү.

29. Урсгал зардлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангилалд тусгагдсан 1,857,913.3 сая төгрөгийг Эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбарт 30 хувиар бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Тэмүүлэн гишүүнд үг өгье.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлынхаа гишүүддээ бас энэ өглөөний мэнд хүргэе. Би энэ зарчмын санал гаргаж байгаа юм. Энэ зарчим нь өөрөө юу юм бэ гэхээр ерөөсөө улсынхаа төсвийн алдагдлыг нь бууруулъя, төсвөө хэмнэе, үр ашиггүй зардлуудыг бид нар бас бууруулж болох, танаж болох, хэмнэж болох зардлуудаа бол хэмнэе л гэдэг зардлыг гаргаж байгаа юм, саналыг гаргаж байгаа юм. Энэ өөрөө юу юм бэ гэхээр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал. Улсын төсөв өөрөө 35,8 их наяд төгрөг байгаа. Энэ дотор 1,9 их наяд нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал буюу үндсэндээ улсын төсвийн чинь 5 хувь нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал боллоо.

Энэ бол Улсын Их Хурлын нэг талдаа онцгой анхаарал хандуулах ёстой ийм зардал болж хувирч байна, зардал болж хувирч байна. Тоо худлаа ярьдаггүй. Би та бүхэнд нэг тоо зүгээр хэлж өгье. Үндсэндээ энэ юу юм бэ гэхээр 2017 онд 324 тэрбум байсан бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал өнөөдөр 7 жилийн дараа 1,9 их наяд төгрөг болсон байна, 6 дахин нэмэгдсэн байна. Өнөөдөр 2023 онд буюу 2 жилийн өмнө бид нарын баталж байсан бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 957 тэрбум төгрөг байсан бол өнөөдөр бараг 1,9 их наяд төгрөг болсон байна, 2 дахин нэмэгдсэн байна. 3 жилийн дотор 1 их наядар нэмэгддэг зардал гэж өөрөө юу юм бэ? Энэ эрүүл өсөлт юм уу, энэ зөв юм уу. Нөгөө төсвийн үр ашиг, төсвийн сахилга бат гэдэг зүйл чинь хаана байгаад байгаа юм.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдгийг та бүхэн анхаараад үзээрэй. Энэ юу юм бэ гэхээр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ бол хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхтэй холбоотой зардал байгаад байгаа юм. Энэ бол аливаа тэр байгууллагын гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх энэ бол дотоод үйл ажиллагаатай хамааралтай зардлууд бол биш юм. Дотоод үйл ажиллагаатай хамааралтай, энэ бол тэр цалин, тэтгэвэр, тэтгэмж, нэмэгдлийн асуудлууд бол энэ биш юм. Энэ нэг талдаа байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангадаг зардал бас биш юм байгаа юм. Хуулийн этгээдээр гүйцэтгүүлдэг, гэрээгээр гүйцэтгүүлдэг зардлууд байгаад байгаа юм, гэрээгээр гүйцэтгүүлдэг. Тэгэхээр магадгүй энэ бол хурал зөвлөгөөн, магадгүй энэ бол зөвлөх үйлчилгээний зардлууд байгаад байгаа юм. Зөвлөх үйлчилгээний зардлууд.

Тэгэхээр энэ асуудлуудаа бид нар онцгой анхаарал хандуулаач. 2023 онд 957 байсан, жилд 450 тэрбум төгрөгөөр нэмэгддэг асуудлыг яах юм бэ. 24 онд 1,4 их наяд төгрөг болсон, 25 онд одоо 1,9 их наяд төгрөг болж байна, 1,9 их наяд. Улсын төсвийн тухай хуулиар бид нар зардлыг нэр төрлөөр нь зардал бүрээр нь, нэр болгоноор нь баталж байх ёстой байгаад байгаа юм. Гэтэл одоо бол үндсэндээ улсын төсөв дотор бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдэг зүйл энэ бүх л дүнгээрээ төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр сууж байгаа зардлууд байгаад байгаа юм. Би энэ өөрөө буруу гэж харж байгаа. Би энийг ядаж буцаагаад ядаж өнгөрсөн жилийнх нь буюу 24 онд батлагдсан төсвийнх нь хэмжээнд аваачиж тавья, 360 тэрбум төгрөгөөр хэмнэе л гэдэг асуудлыг

тавьж байгаа юм. 30 хувь гэдэг нэг аравны, боловсрол, эрүүл мэндийг хасахаар 1,4-өөс хасахаар бол 360 тэрбум төгрөгийн асуудал болж байгаа юм. Тэгэхээр би энийг өөрөө та бүхэн анхаарч үзээрэй.

Дараа нь Улсын Их Хурал бол энэ төсөв төлөвлөхдөө ч тэр, төсөв орж ирэхэд ч тэр, төсвийн гүйцэтгэлийг хянахдаа ч тэр зайлшгүй анхаарч байх ёстой, аудит ч гэсэн энэ дээр анхаарч байх ёстой ийм зардлууд байгаа. Аудитын дүгнэлт гарсан. Та бүхэн хараарай. 2023 оны нэгдсэн төсвийн, нэгдсэн төсвийн аудит хийсэн гүйцэтгэлийн тайлан байгаад байгаа. Энэ дотор 29 дүгээр хуудасных нь 3.1.41 дээр өөр энэ хэлж байгаа зүйл нь бол юу гэхээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас биет болон биет бус хөрөнгө бэлтгэсэн байна, 10,2 тэрбум төгрөг гэж байгаа юм. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ бол үндсэндээ урсгал зардал. Урсгал зардал дотор чинь хөрөнгийн зардал хүртэл суусан байна. Энэ бол 10,2 тэрбум төгрөгөөр байсан байна гэж байгаа юм. Энэ өөрөө юу гэсэн үг юм бэ, энэ аудит хүртэл энэ дээр онцгой хариуцлагатай хандаж, одоо энийг ийм төсөв хооронд нь гүйлгүүлдэг, дотроо зохицуулалт хийдэг, урсгал зардал дотор хөрөнгө оруулалтыг хүртэл шингээдэг ийм дүгнэлт хүртэл гарсан байна шүү дээ 23 оны гүйцэтгэл дээр. Цааш цаашдаа ч гэсэн бид нар 24, 25 оны төсвийн гүйцэтгэлүүд дээр энийг онцгой анхаарч харж байх ёстой асуудал байгаа.

Д.Амарбаясгалан: Эхлээд ажлын хэсгийн дарга, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн үг хэлэх ёстой. Энэ ер нь их зөв ойлгож, зөв санал хураалтад орохгүй бол маш ноцтой асуудал үүснэ. Улсын төсөв задарна, төсвийн хүрээний мэдэгдэл хийх боломжгүй нөхцөл үүснэ гэдгийг бүгд ойлгох. Энэ нэг бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдэг ойлголтыг ерөнхийд нь буруу тайлбарлаад өнөөдрийг хүртэл яваад байх шиг байгаа юм. Тэгэхээр энийг ажлын хэсэг, мөн салбарын сайд 2 энэ дээр зөв ойлголт өгч тайлбараа хийх нь зүйтэй. Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Бид нар энэ зардлын ангиллыг бас эхний үед яг Тэмүүлэн гишүүний ярьж байгаа шиг ойлгочихсон юм. Тэгээд манай яг энэ зарлага, урсгал зардал дээр би дэд ажлын хэсэг Түвшин гишүүнээр байгуулаад, ингээд бид нар энэ зардлыг хянасан байгаа юм. Тэгээд Түвшин гишүүн маань нэг 300 хэдэн тэрбумын асуудлыг эргэж ярья гэж оруулж ирсэн. Тэгээд бид нар ярьсан. Тэгэнгүүт 1 сумын халаалт ч явж байх шиг, ингээд ерөөсөө энэ чинь яг 3 дахь этгээдээр гүйцэтгүүлдэг гэвэл худлаа юм байна лээ. Бидэнд юу гэж ойлгуулсан гээд байвал энд нэг баахан хэвлэлийн ийм янз бүрийн сурталчилгааны зардал яваад байгаа юм гээд л тэгсэн юм. Тэгээд бид нар чинь энэ замбараагүй өсчихсөн юм байна гээд ингэсэн чинь тэр нь 3-хан тэрбум байсан билүү, хэд байсан билээ. Ер нь Түвшин гишүүнээр бас тайлбарлуулчихвал зүгээр байх.

Тэгээд бид нар энэ зардлаас бол 32 тэрбумыг л хасаж болох юм байна гэж үзсэн байхгүй юу. Тэгээд бусдыг нь яг ингээд үзэхээр болохгүй юм байна лээ. Нийтдээ энэ төсөв чинь 3 дахин өсчихсөн байгаа байхгүй юу 21 оноос хойш нийтдээ. Тэгэхээр энийг ингээд инфляцаас болж өсөөд байна уу, юунаас болж өсөөд байна вэ гэдэг юмыг судалж үзэхгүй бол болохгүй юм байна лээ. Яг энэ байдлаар шийдэх юм бол боловсролын салбарын энэ зардлын 30 хувийг аваад хаячихвал боловсролын салбар доголдоод л явчихна. Хамгийн их төсөвтэй учраас. Тэгэхээр механикаар 20, 30-аар, 10-аар гэж ингэж шийдэж бас болохгүй. Тийм учраас дэлгэрэнгүй тайлбарыг Сангийн сайд бас өгөх байх. Бид нар үзсэн, боломжгүй юм байна лээ. 32 тэрбум л гаргаж ирсэн юм.

Д.Амарбаясгалан: Байж байгаарай, төсвийн ажлын хэсэг дээр дэд ажлын хэсэг ахалж байсан Түвшин гишүүн бас нэг тайлбар хийгээдэхье. Түвшин гишүүнд микрофон өгье.

Б.Түвшин: Баярлалаа. Тэгэхээр 24 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 1 их наяд байсан. 25 онд 1 их наяд 486 сая тэрбум төгрөг болж, үндсэндээ 39 хувийн өсөлттэй орж ирж байгаа. Тэгэхээр ерөөсөө энэ урсгал зардал бүхэлдээ асар ихээр нэмэгдээд, төрийн бүтээмж үнэхээр буурч байгаа. Өмнөх оны 22 оны аудитын дүгнэлтүүдийг харахад төсвийн урсгал зардлууд их дүнтэй байна, хамаагүй их шамшигдуулалд гарч байна л гэж байна. Одоо олон нийт социал медиагаас харахад ч гэсэн энд, тэнд ууж идсэн, үргүй зардал гаргасан асар их асуудал байж байгаа. Тэгээд энэ дээр урсгал зардлын ажлын хэсэг бол зардлын нэр, төрөл болгоноор үзэхэд энэ бол тун хүндрэлтэй байдаг. Энэний чинь цаана зөндөө олон төсөл, хөтөлбөрүүд байгаа.

Бүхэлдээ урсгал зардлын нэмэгдлийг бол 30 хувь хасах ёстой. Энэ дээр өөрөө ЗГ өөрөө тодорхой санал оруулж ирэх ёстой. Яг механикаар тодорхой энэ зардлын нэр төрлөөс нь хасъя гэх юм тодорхой тайлбаруудтай байж байгаа. Тэгээд эргээд Даваасүрэн даргын хэлээд байгаа нэг үнэн. Ер нь бүхэлд нь ингээд хасчихаар шантааж хийж байгаа юм шиг аль нэг томоохон төслийн яг энэний хэсгийг нь хасчихлаа гээд ингээд үйл ажиллагааг гацаагаад байдаг. Тийм учраас ЗГ-т юу гэж хэлэх гээд байна вэ гэхээрээ урсгал зардлаа бүхэлд нь энэ оны өсөлтийг нь хасаж орж ирээч гэж байгаа юм. Тэгэхээр би агуулгын хувьд Тэмүүлэн гишүүнтэй санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд.

Б.Жавхлан: Гишүүдийнхээ өглөөний мэндийг эрье. Энэ олон улс, юу олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт OECD, НҮБ-ын стандартад нэг ийм ...of service and goods энэ эдийн засгийн ангиллыг манайх ингэж орчуулаад их олон жил явчихсан юм байна лээ. Энэ жилийн дүн бол өссөн хэсэг нь нөгөө гадаад зээлийн ашиглалт дотор явж байгаа бас дүнгээр 500 гаруй тэрбум төгрөг өсөж гарч ирж байгаа шүү. Бид нар гадаад зээлийнхээ ашиглалтыг гадаад зээлээр явуулж байгаа төслүүдээ бушуухан дуусгая гээд томоохон төслүүд дээрээ бид нар ашиглалтаа нэмсэн шүү дээ.

Өөрөөр хэлбэл тэр Дорноговийн нефть боловсруулах үйлдвэр, Улаанбаатар хотын тэр цэвэрлэх байгууламж гээд томоохон төслүүдээ бушуухан дуусгая, эхлүүлчхээд нэг жил, жил ингээд амсуулаад яваад байхаар төсөл нь дуусахгүй удаахраад, төсөвт өртөг нь нэмэгдээд, маш их эрсдэл гарч байгаа гээд. Ингээд тэр зээл ашиглалт нэмэгдэнгүүт тэр дотор чинь бас бусдаар гүйцэтгүүлэх ийм арга хэмжээнүүд байж байгаа үйл ажиллагаанууд. Тэр нь 500 гаруй тэрбум төгрөгөөр нийт зарлага дотроо энэ нь өөрөө орж ирж байгаа.

Бусдаар гүйцэтгүүлэх гэхээр л энд юу байдаг юм бэ гэхээр жишээ нь Хөдөө аж ахуйн яам дээр вакцин байна. Малын вакцинжуулах. Энийг тангараг өргөсөн төрийн албан хаагч нар айлд очоод хийдэггүй. Энийг хувийн компаниуд энийг хийдэг. Өөрөөр хэлбэл заавал тангараг өргөсөн төрийн албан хаагч хийх шаардлагагүй, хувийн секторт үйлчилгээний төлбөр тарифын дагуу нь шилжүүлээд, тэдгээрээр гүйцэтгүүлэх ийм ажил руугаа л шилжиж байгаа гэсэн үг. Тэрийг хийдэг төрийн албан хаагч нарын тоог нэмэх шаардлага байхгүй. Энэ 360 сумын жишээ нь халаалт байна. Тэр халаалтыг нийлүүлж байгаа компаниас худалдаж авна, үйлчилгээ худалдаж авна. Тэрнээс биш очоод тэр сумын захиргаа халаалт ажиллуулаад, тэндээ дахиад 10 хүн ажилд аваад ингэхгүй. Үдийн цай байна. Наранбаяр сайд та хэлэх хэрэгтэй. Үдийн цайг жишээ нь төрийн албан хаагч нар хийдэггүй шүү дээ. Хоол худалдаж авдаг, үйлчилгээ худалдаж авдаг. Төр өөрөө хийх шаардлагагүй, хувийн сектороо дэмжээд, тийшээгээ энэ мөнгө чинь хувийн секторт л очиж байгаа ийм л төлбөрүүд юм байгаа юм.

Ирэх жил орох цэцэрлэг, сургуулиуд дээр мөн боловсролын салбар дээр жишээ нь 50 хэдэн тэрбум төгрөг нэмэгдэж байгаа. Тэр нь дандаа нийтлэг үйлчилгээний албан хаагчдын тоог нэмэгдүүлэхгүйгээр, тэднийхтэй ижилхэн үйлчилгээ үзүүлдэг компаниудаас тарифжуулаад үйлчилгээ худалдаж авах ийм л төлбөрүүд байгаа юм. Тэгээд ингээд 1 хувь хасаж болно, 2 хувь хасаж болно, 3, 4, 5 хувь ойлгож болно, тэвчиж болно. Ковидын үед бид бүгдээрээ төсвийн ерөнхийлөн захирагч нар нэг дуугаар зардлууд дээрээ танаад, ёстой цаашаа харж уйлаад л, ингээд арга хэмжээнд авч байсан. 30 хувь гэдэг бол хувийн секторт очих төлбөр, энэ хөрөнгө оруулалтуудаас хасаж байна. Нөгөө тал нь ЗГ-ынхаа 3 үйл ажиллагааных нь 1-ийг нь хөлийг нь тушиж байгаатай аягүй адилхан. Хэрвээ тийм санаа байгаа бол энийгээ арай өөрөөр илэрхийлэх бас болно.

Тийм учраас энэ үйл ажиллагааг гэнэт зогсоох ийм 30 хувийн ийм эрсдэл байж болохгүй юм. Тэгэхээр энийг бас ингээд зөв талаас нь хараад, энэ дээрээ нэлээн суугаад, задалж харах юм бол энэ яг хувийн, дахиад хэлье хувийн сектор луу хийж байгаа хөрөнгө оруулалтууд, үйлчилгээнүүд. Төр өөрөө данхайхгүй байх нэг хувилбар нь бас энэ. 3 жилийн өмнө бид нар бүр нийтлэг үйлчилгээг тэр чигээр нь хувийн секторт хийе гээд үйл ажиллагааны зардлаас нь ангиллаас нь гаргаад бусдаар үйлчлүүлэх гээд, үүний үр дүнд бол 30-аас 40 мянган төрийн албан хаагчдын тоо буурах байсан. Тэрийг бид нар бас гэнэт хийчихсэн учраас нийгэм хүлээж аваагүй, чадаагүй. Одоо тэгвэл цаашдаа ядаж нэмэгдэх зардлууд дээрээ хувийн сектороос худалдаж аваад, төрийн албан хаагчид тэр хэмжээгээр тоог нь нэмэгдэх энэ нэмэгдлээсээ татгалзаж байгаа бас нэг талын энэ чинь төсвийн реформын шинжтэй ийм үйл ажиллагаа юм. Тийм учраас Төсвийн байнгын хороон дээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: ЗГ-ыг төлөөлөөд гэж нэг үг, тийм ээ тийм, яах вэ ЗГ-ыг төлөөлөөд Хууль зүйн сайдаар бас нэг тайлбар хэлүүлье. Ер нь санал гаргасан гишүүн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэх дэгтэй. Гишүүний хэлж байгаа асуудал нь өөрөө бас энэ төсөвтэй холбоотой нөхцөл байдал байгаа учраас ажлын хэсгийн дарга, Сангийн сайд, ажлын хэсэг дотор дэд ажлын хэсгийг ахалж байсан гишүүн нараар үг хэлүүлсэн байгаа. Хууль зүйн сайд энэ дээр үг хэлье гэж байна. Тайлбар авъя. Алтангэрэл сайдын микрофон.

О.Алтангэрэл: Сайд нар болгонд л асуудал, ярих юмнууд байгаа байх. Би зүгээр өөрийнхөө салбарын тухай товчхон хэлье. Энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр гээд бид нар чадлаараа л үйл ажиллагаагаа өргөжүүлчихье гээд нэлээн өндөр болгоод ороод ирэнгүүт Сангийн яаман дээр нэлээн хасаж, танаад ингээд ороод ирсэн. Бид нар ганцхан жишээ хэлье. Өнөөдөр цагдаагийн байгууллагыг эрүүдэн шүүлт хүний эрх ярьж байгаа. Бид нар цагдаагийн байгууллагын мөрдөн байцаалтын өрөөнүүдийг прокуророос зөвшөөрөл аваад камертай, мэдээллийн технологи AI ашигласан чимэгэ системээр хүний яриаг автоматаар бичдэг, засварлах боломжгүй болгож тоноглож байгаа. Бид нар чимэгэ системийг хийж байгаа ажлыг төр хийж чадахгүй. Бид нар авахаас аргагүй. Энэ төсөв оруулж ирсэн.

Дахиад өнөөдөр Монгол орон даяар эргүүл хийгээд явж байгаа цагдаа нарын машин унаа бүгдийг нь даатгуулж байгаа юм. Бид нар энийгээ яаж хасах юм, даатгалгүй машинд суугаад яв гээд албан хаагчдаа явуулах уу? Дахиад өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй хорих анги, хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг хариуцаж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар байна, цагдаа байна. Эдгээр тусгай чиг үүргийн байгууллагуудын гүйцэтгэх ажлын чиг үүрэгтэй холбоотой зүйлүүд энэ дотор байгаа. Бид нар юу гэх юм төсвийг чинь хасчихсан та нар 30 хувь хулгайчийнхаа хойноос

дутуу яваарай, 70 хувь гэмт хэрэгтэй тэмцээрэй ингэж хэлэх бололцоогүй болчхоод байгаа байхгүй юу.

Маш олон төрлийн хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхээс аргагүй, төлөхөөс аргагүй, урьд нь төлөөд ирчихсэн, хэвшчихсэн бид нарын боломж бололцоо хүрэхгүй ийм зүйлүүд байгаа юм. Тэгэхээр гишүүдийгээ бас энэ асуудалд ойлгож хандаасай гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ингээд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэнгийн гаргасан Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хэдэн гишүүн санал өгч чадаагүй юм бэ, гараа өргө дөө. Алдаржавхлан, Номин, Батжаргал, Батлут, Болормаа. Болормаа гишүүн.

Э.Болормаа: Энэ төхөөрөмж дээр энэ улаан тэмдгээр wrong credential гэхсэн байгаа учир би дэмжих санал маань орж чадсангүй. Тэгээд санал хураалтыг дахин явуулж өгнө үү гэж хүсье. Санал хураалтыг цуцалж, дахиж явуулж өгнө үү гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Гишүүд, тийм. Гишүүд Дэгийн тухай хуулийн 13.2-ыг уншаадах та хэд. 13.2 дээр хуралдаан даргалагч горимын саналаар нэг удаа санал хураалт явуулна. Гишүүнээс гаргасан нэг горимын саналаар нэгээс илүү санал хураалт явуулахгүй. Дараагийн гишүүн горимын санал гаргахад түүгээр бас нэг удаа санал хураалгана гэсэн заалт нь байж байгаа. Нэг асуудал гэдэг чинь Лодойсамбуу гишүүнээ нэг санал хураалтыг чинь нэг асуудал гэж үзнэ. Нэг асуудалтай холбоотойгоор санал гаргаж байгаа горимын саналаар санал хураалгахаас өөр арга байдаггүй гэдгийг бас, дэмжих, дэмжихгүй нь гишүүний эрхийн асуудал. Тийм учраас Болормаа гишүүний гаргасан горимын саналаар 29 дүгээр саналыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Минийх ч бас алдаа гараад, 55,8 хувиар санал дэмжигдлээ.

29 дэх саналыг дахиж санал хураана. Мэдээж санал гаргасан гишүүн Тэмүүлэн гишүүн хэмнэлт хийх чиглэл дээр агуулга санаачилгыг гаргасан. Гэхдээ ажлын хэсэг, Байнгын хороо шууд 30 хувь гэж ийм хувь тооцсон хэлбэрээр танаж байгаа хэлбэр нь маш олон салбарт доголдол үүсэх эрсдэлийг бий болгоно гэдэг асуудлыг ярьсан. Гэхдээ энэ Улсын Их Хурлын гишүүдийн хэлж байгаа саналыг харгалзан үзэж, ер нь салбар болгон хэмнэлт хийх чиглэл дээр анхаарах хэрэгтэй. Ер нь дараа, дараа жилийн төсөв орж ирэхдээ яг энэ чиглэлийг зөвхөн төсөв хэлэлцэхэд биш, урьдчилж төсвөөс урьдчилж энэ асуудал дээр өргөн хүрээгээр ажилладаг болох ийм шаардлагатай байгаад байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бүх талын оролцоог хангасан энэ ажлын хэсгийг байгуулъя гэж бид үзэж байгаа. Энэ ажлын хэсгийн хүрээнд ч гэсэн бид энийг маш сайтар ярьдаг байх хэрэгтэй. Зүгээр өнөөдөр шууд ингээд л хүчээр тайраад хаячихаар энэ амьдрал өөрөө ямар нөхцөл рүү орох вэ гэдгийг ч гэсэн улс төрч хүмүүс олон талаасаа бодож байгаа байх гэж бодож байна. Ингээд 29 дэх саналыг санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 13 дугаар зүйл буюу Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 3,500,000.0 сая төгрөг гэснийг 2,500,000.0 сая төгрөг гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Тэмүүлэн гишүүнд микрофон өгье.

Г.Тэмүүлэн: Би энэ саналыг бас гаргасан юм. Энэ яасан гэхээр ЗГ-ын өрийн баталгаа гаргах хязгаарыг нь 1 их наядаар бууруулъя л гэсэн асуудал байгаад байгаа юм. Яагаад вэ гэхээр нэг талдаа бонд гаргана гэдэг бол нэг талдаа энэ бол өр зээл гэсэн үг.

Өнөөдөр улсын төсвийн магадгүй хамгийн том эрсдэлийн нэг асуудал нь өөрөө энэ зээл болчихоод байгаа асуудлууд. Энэ дээр хуулийнх нь үзэл баримтлалынх нь хүрээнд өргөн баригдсан төсвийнх нь хүрээнд 2,5 их наяд үндсэндээ яг бодит хэрэгцээ шаардлага нь байна. Өнөөдөр ЗГ-ын дахин санхүүжилт өөрөө 578 сая буюу Номад бондын 2 их наяд байгаа, ЗГ-ын дотоод үнэт цаас 300 тэрбум, Нийслэлийн бонд 190 тэрбум, ингээд үндсэндээ дээд дүн 2,5 их наяд төгрөг байгаа.

Тэгэхээр энэнээс илүү нэг талдаа бид нар бонд гаргах, ЗГ-ын өрийн баталгаа гаргах магадгүй ирээдүйдээ нэг талдаа ийм төсвийн эрсдэл үүсгэх шаардлага байхгүй л гэж харж байгаа. Энэ үүднээс төсвийнх нь үзэл баримтлал болоод энэ төсвийнх нь хүрээ хязгаарынх нь хүрээнд хязгаарлаж өгсөн зүйл байгаад байгаа юм. Хэрэв магадгүй цаашдаа ямар нэг байдлаар дахиж шинээр бонд гаргах гэдэг юм уу, өрийн баталгаа гаргах шаардлагатай асуудлууд бол тэрийг Төсвийнхөө хуулиар ч гэсэн тусад нь оруулж ирээд, энийгээ хэлэлцүүлээд, батлуулаад яваад байх эрх нь нээлттэй. Эрх нь нээлттэй. Улсын Их Хурал өөрийнхөө онцгой бүрэн эрхийн хүрээнд энэ өрийн удирдлага, менежментийн хүрээнд тухайн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх эрх нь нээлттэй байх ёстой гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ үндсэн дээр би нэг талдаа оруулж ирсэн үзэл баримтлалынх нь хүрээнд бол хязгаарлаж өгч байгаа ийм асуудлууд байгаа юм. Гадаад зээл авна, бонд гаргана, өрийн дарамт үүснэ, эргээд бид нар нөгөө талдаа эдийн засгаа яах вэ гэдэг асуудал үүсэж байгаа юм. Төсвийнхөө цаашдынхаа ачааллуудыг яах вэ гэдэг асуудлууд байгаа юм. Тэгэхээр бид нар нэг талдаа аль болох л хязгаарлаж болох, танаж болох, хэмнэж болох зүйлүүд дээрээ хязгаарлалтуудыг хийх ёстой. Түрүүний ярьж байгаа асуудлууд дээр ч гэсэн Монголын мал 40, 50 хувь өсөөгүй шүү дээ. Би хүсээд байгаа зүйл нь энэ бүх зардлуудаа төсөв дээр нэг бүрчлэн нэрээр нь оруулж ирээч гээд байгаа шүү дээ энэ сайд нарыг. Яагаад та нар бүхэл дүнгээр нь тавиад байгаа юм бэ? Тэр үнэхээр онцгой хэрэгтэй зардлууд байгаа бол тэрийгээ нэг бүрчлэн, ангилал болгоноор нь, нэрээр нь, зардал болгоноор нь тавиач. Бүхэл дүнгээр тавьж байгаа чинь асуудал үүсгээд байна шүү дээ. Яахаараа нэг жилийнх нь зардлын өсөлт нь 45-аас 50 хувь өсдөг юм, энэ зөв юм уу? Буруу шүү дээ.

Д.Амарбаясгалан: Шууд санал хураалт руугаа ордог юм уу? Дахиж хэлэлцүүлэг явах гээд байх юм. Тайлбар хийвэл яах вэ ажлын хэсгийн дарга энэ дээр тайлбар хийж болно. Алга байна. Тэгвэл Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэнгийн гаргасан Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. 48,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

31.Төслийн урсгал зардалд туссан Зээлийн үйлчилгээний төлбөр 1,303,370.7 сая төгрөг гэснийг 1,263,370.7 сая төгрөг гэж өөрчлөх. Жавхлан сайд яах гэсэн билээ? Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Энэ ингээд түрүүлж буруу тайлбар өгөөд байх юм. ЗГ-ын 4 жилийн хөтөлбөр гээд энэ шинэ Их Хурал маань сарын өмнө баталсан. 14 мега төсөл, 14 реформ гээд. Тэдгээр ажлууд маань дийлэнх нь одоо яг зураг, төсвийнхөө ажил дээр явж байгаа. Зураг, төсвийнхөө ажил дээр явж байгаа. Хэчнээн их наяд төгрөгийн төслүүд болохоо ч одоогоор бид хэн нь ч сайн мэдэхгүй байгаа. Ямар ч байсан төлөвлөгөөндөө оруулчихсан, үүнийхээ ардаас Их Хурал мөн дэмжээд энэ төлөвлөгөөг баталчихсан. Одоо бид дундаас нь ухраад, нэг дэгээ тавиад, хоёрын хооронд нэг ийм ЗГ-ынхаа үйл ажиллагааг нэг доголдуулаад, ямар санаа агуулаад байгаа юм, нэг иймэрхүү байдлаар хандмааргүй байгаа юм.

Хэрвээ хасья гэж байгаа бол бүр тэг гээд хасчих хэрэгтэй шүү дээ. Бүр санаагаа илэрхий хэлэх хэрэгтэй. 3,5 их наяд байна уу, 2,5 их наяд байна уу бараг ялгаа байхгүй. Ингээд дүн юмнууд нь тодорхой болж ирээд, ТЭЗҮ нь тодорхой болоод ирэхээр магадгүй ЗГ-аас баталгаа гаргах ийм төслүүд гарч ирэхийг болзошгүй шүү дээ. Энэ 3,5 их наяд чинь нөгөө гадаад зээлийн өр 42,6 хувь дээр хязгаар дотроо байна гэж байгаа бид нарын төлөвлөлт дотор орчихсон байгаа дүн. Ороод 42,6. Нөгөө 60 байхаас чинь 42,6 гээд бид гүйцэтгэлээрээ ингээд гарч байна.

Яг тухайлан ямар төсөл дээр баталгаа гаргах чинь дахиад Их Хурлаар орж ирнэ. Тэгэхээр нэг хоёрын хооронд нэг ийм юман дээр ингээд шал дэмий л санал гаргаж байгаа юм. Би Тэмүүлэн гишүүнд өөрт нь бас хандаж хэлсэн. Энэ саналуудаа татаад авчхаач. ЗГ чинь 100 ч хоноогүй байна. Төлөвлөгөөгөө баталчхаад, тэгээд гараан дээр нь дахиж ингэж дэгээдэж унагаагаад, 3 үйл ажиллагааных нь 1-ийг нь зогсооё гэж байна. 3,5 их наяд гэдэг чинь нөгөө л төслүүд дээрээ л гаргана шүү дээ. Хаанаас ч тэнгэрээс бууж ирэх шинэ төсөл гэж гарч ирэхгүй. Нөгөө 14 төслөө л явуулахын тулд аль нэгэн дээр нь гарч байж шаардлага гарч байж магадгүй баталгаа гаргах. Ийм л зүйлүүд байгаа.

Дараагийнх нь энэ дүн байна. Энэ дүн бид 3 зээлжих зэрэглэлийн компаниар үнэлгээгээ хийлгэдэг. 2 нь сайжирчихлаа, одоо Moody's-ийг хүлээж байна. Ингэж байгаад Moody's хэрвээ сайжраад гараад ирэх юм бол бид нар ирэх жил 26, 27 онд гарах дуусах бондуудынхаа хугацааг нааш нь татаад, хойтон refinance хийх боломж гарч байгаа. Өөрөөр хэлбэл зардал буурна гэсэн үг, зардал буурна. 26, 27 оны зардал буурна. Тэр refinance хийх зардлын мөнгийг нь энэ 1 их наяд 303, 1 их наяд 263 гээд 40,6-гаар буулгачхаж байгаа байхгүй юу. Тэгж яах гэсэн юм бэ, бид нар чинь том зардлаа буулгахын төлөө гаргаж байгаа ийм зардлыг энэ хэрэггүй зардал гээд ингэж бас болохгүй шүү дээ. Өөр санаа байгаа бол тэрийгээ шууд хэлэх хэрэгтэй. Дэмий юман дээр ингээд үйл ажиллагааг доголдуулах хэмжээний юмыг бүр ингэж нэг аягүй сайхан малгай өмсгөж байгаад ийм тайлбартайгаар зүтгүүлмээргүй байна. Тийм учраас гишүүд минь энэ саналыг Төсвийн байнгын хорооны гаргасан, юу дэмжээгүйг энэ саналыг дэмжиж өгөөч гэж та бүхнээс чин сэтгэлээсээ ЗГ-ынхаа өмнөөс хүсэж байна шүү.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга микрофон өгье.

Ц.Даваасүрэн: Би зүгээр ЗГ нь том, том ажил хийчихье гээд байхад нь мөнгөөр боогоод суугаад байвал утгагүй л болчих байх л даа. Тэрийг нь шийдэж өгчхөөд, харин хийж байна уу, хийхгүй байна уу гэдэг дээр нь хяналтаа тавиад шаардаад сууж байх нь дээр байх. Одоо ингээд бид нар ингээд багасгаад хаячихаар эд дараа нь тэгнэ шүү дээ. Үгүй ээ та нар баталж өгөөгүй шүү дээ, тэгээд бид нар хийгээгүй шүү дээ л гэх байхгүй юу даа. Тийм учраас сая тэр баталгааг нь уг нь нэг их тэгээд хасах хэрэг байсан юм уу даа мэдэхгүй.

Тэр зээлийн үйлчилгээний төлбөрийг бол болохгүй шүү. Аливаа зээл графикийн дагуу төлөгдөж байгаа. Зээлийн үйлчилгээний төлбөр гэдэг чинь байна шүү дээ үндсэн төлбөр, хүүгийн төлбөр хоёрыг нийлснийг хэлж байгаа юм. Тийм учраас бол энэ график төлбөр. Зүгээр зээлийн үндсэн төлбөр дээр зарим нэг төлбөрийг хэрвээ ашигтай байх юм бол төлчихье гэж байгаа юм байна лээ. Тийм учраас энэ зээлийн графикийн дагуу төлөгдөх ийм юман дээр, энэ чинь ямар өөр юманд ашиглаж болох биш дээ. Ийм юман дээр ингэх хэрэг байсан юм уу, би ойлгохгүй л байна. Энийг нь та бүхэн бас анхаараарай. Энэ зээлийн үйлчилгээний төлбөр дээр бол бид нар тэгж болохгүй. Энэ Засгийн оруулж ирснээр нь явуулах хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Болсон. ЗГ-ын гишүүд тэгээд энэ оруулж ирсэн төслийнхөө эсрэг санал өгөөд байна шүү дээ Сангийн сайдаа. Эрдэнэбилэгийн Одбаяр, Борхүүгийн Дэлгэрсайхан, Сандагийн Бямбацогт. Тэгээд өөрсдөө тэгээд танхимд орж ирж саналаа өгөхгүй, хариуцлагагүй. Тэгчхээд Улсын Их Хурлын гишүүдэд магадгүй Улсын Их Хурлын гишүүд санал гаргах эрхтэй. Энэний зөв, бурууг мэргэжлийн Байнгын хороо ажлын хэсэг дээр ярилцаад, эцэслэн шийдэх ёстой. Улс орны төсөв, эдийн засагт аюул учирчих вий гэдэг зүйл дээр л болгоомжилж, зарим нэг санал горимын санал гарсан, дахиж санал хураалт явж байгаа. Зарим Улсын Их Хурлын гишүүд нь огт горимын санал гаргаж болохгүй юм шиг нэг ойлголттой. Энд чинь бас алдаа дутагдал гарч байна. Буруу, зөрүү ойлгосноос болж горимын санал гаргаж, саналаа буруу дарснаас болж горимын санал гаргаж, дахиж санал хураалт явуулж байна. Энэ дээр буруудаад байх зүйл байхгүй.

Тэгэхээр энэ мэтийн жижигхэн улс төрөөсөө илүү том улс орныхоо энэ бодлогын асуудал дээр жоохон анхаарлаа хандуулж, цаг гаргаж суу. Одоо ингээд л горимын санал гаргаж санал хураалгалаа гээд шүүмжилж байгаа гишүүн танхимд 10 минут сууж чадахгүй юм. Орж ирж 10 минут суучаад л 1 ч удаа дэмжсэн санал өгөхгүй. Бүх санал дээр эсрэг. Тэгсэн мөртөө л горимын санал гаргалаа гээд л олон юм яриад л, гараад л улс төр хийхээ л бодоод байх юм. Энд чинь улс орны амьдрал явж байна шүү дээ. Монголчуудын амьдрал, маргаашийн амьдралыг өнөөдөр бид шийдэх гээд сууж байна гэдгээ бас бодох хэрэгтэй. Улс төр хийх бол нэг хэрэг. Тэгэхээр энэ санал өгч байгаа процесс дээрээ жоохон хариуцлагатай ханд.

31.Төслийн урсгал зардалд туссан Зээлийн үйлчилгээний төлбөр 1,303,370.7 сая төгрөг гэснийг 1,263,370.7 сая төгрөг гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. 31, одоо ажиллаж байгаа юм уу, цаана чинь ажиллахгүй байгаа юм уу? Дахиад уншуулаач. Ингээд 31 дүгээр санал Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг, Тэмүүлэн гишүүн яах юм бэ? Үгүй ээ үгүй тайлбар өгчихсөн, өгчихсөн түрүүн өгчихсөн, өгчихсөн шүү дээ. Тэмүүлэн гишүүнд микрофон өгье. Санал гаргасан гишүүн тайлбар.

Г.Тэмүүлэн: Энэ 31 дэх санал нь бид төсвийн урсгал зардал дээр туссан зээлийн үйлчилгээний төлбөрөөс 40 тэрбум төгрөгийг хасъя гэж байгаа юм. Энэ бол гишүүн болгон нөгөө төсвийн талаарх тодорхой мэдээлэл байхгүй, Төсвийн байнгын хороонд суухгүй учраас бас яг юуг хасах гээд байгаа юм гэдгийг нь ойлгохгүй байж магадгүй гээд байгаа юм. Би энэ та бүхэнд яг задаргаагаар нь хэлж өгөх гээд байгаа зүйл маань зээлийн үйлчилгээний зардал гэдэг дотор үндсэндээ 40,6 тэрбум төгрөгийн ямар ч зориулалт нь тодорхойгүй зардал яваад байгаа юм. Яагаад вэ гэхээр Номад байна уу, тэр Сенчири бондуудынх нь бүх хөрөнгө зардлуудыг нь суулгаад өгчихсөн байгаад байгаа юм. Энэ дотор зөвхөн өрийн зохицуулалт буюу дахин санхүүжилт гэдэг нэрийн дор 40,6 тэрбум төгрөг байгаад байгаа юм. Би энийг урьд нь Сангийн сайд хэлсэн. Байнгын хороон дээр бас хэлсэн асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ юу юм бэ гэхээр нэг талдаа үндсэндээ 1 тэрбум ам.доллар би зүгээр мөнгөн дүнгээр нь тооцож үзэхээр 3,5 их наяд төгрөг буюу 1 тэрбум долларын бонд гаргах, гаргаад магадгүй тэрний зээлийн үйлчилгээний зардал байна гэж хараад байгаа юм. Зээлийн үйлчилгээний зардал байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр аливаа бид нар төсөв баталж байгаа процесс дунд бүх зүйлүүд тодорхой байх ёстой, тодорхой байх ёстой. Тэгэхээр үндсэндээ төсөв баталж байгаа учраас юу ч магадгүй гэж төсөв тооцоолж болохгүй байхгүй юу. Юу ч магадгүй гэж төсөв тооцоолж болохгүй. Дахин санхүүжилт хийх асуудал бол үндсэндээ магадгүй бид нарын тэр тавьчихсан байгаа Номадых,

Сенчирийнх тэр бондуудын зардлууд чинь дахин буурна гэсэн үг. Магадгүй би тэрийг бас үгүйсгэхгүй. Тэр Номадын 5 хувиар авсан олон улсын зах зээл дээрээс босгосон тэр бондын зардлыг бууруулна гэсэн үг байхгүй юу үндсэндээ.

Тэгэхээр өнөөдрийн бид нарын энэ 1,3 их наяд төгрөгийн зээлийн үйлчилгээний зардал чинь буух боломжийг бий болгоно л гэж байгаа асуудал байгаад байгаа. Бид нарын тусгачихсан 1,3 чинь буух боломжтой гэсэн үг. Гэтэл дахиад цаана нь 40,6 тэрбум буюу магадгүй 1 тэрбум долларын бонд гаргах ийм зээлийн үйлчилгээний зардлыг л суулгаад байгаа юм. Үнэхээр тийм байгаа бол тэрийгээ хэлээд тодорхой тусгаад оруулж ирэх хэрэгтэй шүү дээ. Яагаад сул мөнгө 40,6 гэж тавиад байгаа юм гэсэн асуудал байгаад байгаа юм.

Үндсэндээ бид нар энэ хэрэв юу гэдэг юм үнэт цаас тэр гаргах гээд байгаа гэдэг юм уу тийм асуудлууд байгаа бол тэрийг чинь Улсын Их Хурал бид нар шийдэж өгөөд, батлаад байх ийм боломж байна шүү дээ. Тэрнээс би асуудалд зарчмын үндсэн дээр хандаж байгаа болохоос биш хэрэв юу гэдэг юм үнэт цаас гаргах гээд байгаа бол тэр эрхийг чинь Улсын Их Хурал шийдэж өгч болно шүү дээ. Дахиж оруулж ирж болно, шийдэж өгч болно. Гэтэл юу гэдэг юм яг тодорхойгүй байдлаар энэ зардлыг төсөвлөж оруулж ирээд байгаа энэ асуудлууд чинь бодит дүн дээр нь асуудлыг тавихгүй байгаа асуудлууд чинь таалагдахгүй байна яг үнэндээ. Бид нар үндсэндээ энэ инфляц өснө, энэ нөхцөл байдал хүнд байна.

Магадгүй энэ зээл үйлчилгээний төлбөрийн зардлууд чинь их байна. Төсвийн алдагдлыг бууруулна. Бид бүхний өмнө нь амласан асуудлууд зөндөө байгаа шүү дээ. 3 намын мөрийн хөтөлбөр дээр ч гэсэн бид нар улсын төсвийн чинь зардлыг бууруулна, алдагдлыг бууруулна гэдэг асуудлуудыг тавьж өгч байсан шүү дээ. ХҮН намынх, Ардын намынх, АН-ынх. Бид нарын мартсан зүйлийг бас сануулж өгч байгаа би бас Энхтүвшин гишүүнд баярлалаа гэж хэлж байгаа юм. Энэ заалт болгоноо бид нар харах хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Энэ зардлыг чинь бид нар бууруулъя, өрийн дарамтыг бууруулахад бид нар юу гэдэг юм эрсдэлийг нь багасгадаг байя гэдэг асуудлуудыг тавиад байгаа шүү дээ.

Гэтэл яагаад юу гэдэг юм ийм тодорхойгүй, магадгүй гэдэг байдлаар, тооцоолж болзошгүй гэдэг байдлаар зүйлүүдийг тавиад байгаа юм бэ. Энэ нэг талдаа буруу. Үндсэндээ энэ 30 аравны, 35,8 их наяд төгрөгөөс бид нар бас тодорхой хэмжээнд ч гэсэн зардлын хэмнэлтүүд гарах шаардлагатай шүү дээ. Энэ бол нэг талд шууд энэ зардлыг хаслаа гэхэд ямар ч тэр зээлийн үйлчилгээний зардал дээр ямар ч эрсдэл учруулах асуудал байхгүй, байхгүй. Хэрэв дахин санхүүжилт хийх гэж байгаа бол тэрийгээ оруулж ир дахиад. Энэ чинь зүгээр л магадгүй гэсэн зардлыг та тавьчихсан байгаа байхгүй юу 40,8 тэрбум төгрөг. 40,8 бол бага зардал биш шүү.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан тайлбар хийе.

Б.Жавхлан: Их Хурлын даргаа түрүүн тэр Одбаяр сайд санал гаргасан шүү дээ. Та тэрийг нэг анхаарч өгөөрэй. Гишүүний хэлсэн тайлбар дээр бас бид нар мэдээлэл дутуу өгсөн юм шиг байна. Уучлаарай.

Энэ ийм юм байгаа юм. Жишээ нь 2026 оны 4 сард төлөх Номад бондын купоныг хойтон бид нар 2 удаа төлнө 4 сард, 10 сард. Тэгэхээр хойтонгийн яг товлогдсон хүү 10 сардаа ингээд зарцуулагдаад дуусчих юм байгаа юм. Хэрвээ 10 сарын 7-ноос 12 сарын 1 хүртэл 57 өдөр байгаа юм. Энэ хооронд хэрвээ зээлийн хүү буулгах бидэнд тийм цонх

боломж үүсвэл бид нар тэр боломжийг алдаж болохгүй. 26 оны 4 сард төлөгдөх Номад бондын тэр хүү маань цаашдаа дахиад 4 жил бага хүүгээр явах энэ чинь бараг 40, 50 сая долларын асуудал яригдана бид нар зардлаа хэмнэх бууруулах. Тэр 57 өдрийн наана бид нар дахин санхүүжилт хийх боломж гарах юм тэрийг ашиглая гэж байгаа л ийм зардал. Цаашид гарах, ирээдүйд гарах зардлыг магадгүй 10, 20 дахин буулгахын төлөө л гаргах гэж байгаа ийм маркет дээр хийгдэж байгаа ийм маневр байхгүй юу.

Зах зээл дээр хүү яаж хөдлөх юм, боломж яаж гарч ирэхийг хэн ч өнөөдөр хэлж мэдэхгүй. Бид нар энэ дээр бэлэн байж байх ёстой. Энэ тэгэх гэж Сангийн яамны бид өрийн удирдлагын менежмент гэсэн маш том алба өөрөө ажиллаж байдаг, ийм юм байгаа юм. Энэ бол маш тодорхой байхгүй юу. 40 тэрбум маань энэ 10 сая, 10 сая 700-гаад мянган ийм доллар юм байгаа юм. Тэр нь 57 хоногийн хүү гэхээр 3 сая, refinance хэрвээ гаргахаар 3 сая долларын зардал гарна. Мөн яг зах зээл дээр хэрвээ бид нар 100-аас дээш яваад байгаа 1 хувийн премиум нь бас 3 сая доллар орчим ингээд нийлээд 10 сая доллар болж байгаа юм. Ийм л зардал байгаа юм. Энийг хэмнэх юм бид нар хүүгээ буулгах боломж гарсан үед хөдөлж чадахгүй л гэсэн үг. Ийм л боломж байгаа юм. Манай Доржханд сайд бол энэ дээр маш сайн мэднэ. Яг энэ дээр өөрөө яг маркет дээр ажиллаж байсан хүн. Энэ дээр та нэг бас тайлбар хэлээч?

Д.Амарбаясгалан: Шадар сайд Доржханд үг хэлье. Энэнээс өмнө ер нь энэ ажлын хэсэг, Байнгын хороон дээр Тэмүүлэн гишүүнээ та хэд маань их сайн ярилцаагүй юм уу ер нь? Тэгээд ярилцаад тэгээд ингээд Байнгын хороо харин тийм, сайхан ойлголцоод нэгэнт тэнд асуудлаа олонхоороо шийдсэн бол өнөөдөр Их Хурал дээр орж ирж асуудлуудыг ингэж нөхцөл байдлыг нэлээн ийм шахаанд оруулах бол шаардлага бага л баймаар юм уг нь. Шадар сайд Доржханд.

Т.Доржханд: Баярлалаа. Би яг энэ ажлыг бас нэг Монгол Улсын Сангийн яаманд 10 гаруй жил хариуцаж ажиллаж байсан хүний хувьд яг улс төрчийн биш мэргэжилтэн хүний хувиар ганц мэдээлэл хэлчихье. Юу вэ гээд тэгэхээр Монгол Улс хөгжиж байгаа эдийн засагтай. Тэгээд Монголчууд бид нар нөгөө гаднаасаа мөнгө босгодог, дотроосоо мөнгө босгодог. Энэ ингээд 2 хөрөнгийн зах зээл байгаа юм.

Гадаад зах зээл дээр бид нар нөгөө бенчмарк гэж ярьдаг, яг энийгээ ингээд тогтоох ёстой байхгүй юу. Эндээ зориулж төсөв гаргадаг. Тэгээд хэрэв ингээд өгөөж нь ингээд буураад хямдраад ирэх юм бол бид нар өөрсдөө худалдаж авах ёстой. Өсөөд ирэх юм бол тэрийгээ ингээд хадгалаад явдаг ч гэдэг юм уу ийм байдлаар ингээд гадаад зах зээлийнхээ түвшинд бид нар ингээд оролцож явах ёстой юм нэг.

2 дугаарт болохоороо өнөөдөр Монгол Улсын түүхэнд анх удаагаа ОУВС 2025 оны эдийн засгийн өсөлтийг 7 хувь болгосон. Хэзээ ч тийм байгаагүй, хэзээ ч тийм байгаагүй шүү. 2012 оны 17 хувь эдийн засгийн өсөлттэй байх үед хүртэл тийм өсөлтийг Валютын сан гаргаж ирж байгаагүй байхгүй юу. Үүгээрээ юу хэлж байна гээд тэгэхээр бүх олон улсын байгууллагууд манай өсөлтийг өндрөөр хүлээж авч байна.

2 дугаарт зээлжих зэрэглэл гэдэг бол хөндлөнгийн 3 байгууллага тогтоодог. Эд нар үнэлгээгээ өсгөөд байгаа юм. Юу вэ гэхээр энэ бол момент юм байна гээд. Яг энэ момент дээр бид нар тэлэх бодлогоо ингээд явуулдаг. Тэгээд эдийн засаг ингээд хүндрээд ирэх юм бол агших бодлогоо явуулдаг. Гэтэл манай нөгөө гишүүд болохоор төсвийнхөө зарлагыг хяна, агшаа, хяна гээд байгаа. Гэтэл эдийн засгийн цикл чинь өөрөө ингээд дээшээ, доошоо ингэж явдаг. Тэлэх үед нь бид нар тэлэх ёстой. Одоо ингээд ковидын дараа эдийн засгууд тэлэх гээд хүлээж байна. АНУ-ын сонгуулийг ингээд хүлээж байна. Бүх

үзүүлэлтүүд тэлэх юм байна гэдэг ийм байдалтай байхад бид нар ингээд бариад, эдийн засгаа ингээд борцлоод байж болохгүй байхгүй юу.

Тийм болохоор агуулга нь юу вэ гэхээр тэнд бас ингээд хэлээд байна л даа. МАН, АН, ХҮН намууд ингээд тухайлбал өөрсдийнхөө энэ мөрийн хөтөлбөрт тусгасан бодлогоо бариач гээд. Үгүй ээ үгүй. Мөрийн хөтөлбөр дээр бид нар эдийн засагт оролцох төсвийн оролдлогыг хязгаарлана гээд тэгсэн. Гэтэл одоо бол энэ чинь өөрөө ингээд гадаад зах зээл Монгол Улсын зарласан тэр 14 мега төслүүдэд нар чинь бүгдээрээ эдийн засгаа бодитоор тэлэх боломж байна гээд, тэгээд үнэлгээг нь олон улсын байгууллагууд хөндлөнгөөс хийчхээд болж байна гээд явж байгаа энэ тохиолдолд энд ингээд бид нар болохгүй, болохгүй, хязгаарлалт хийгээд явах юм бол энэ өөрөө бид нар энэ боломжоо алдчих гээд байгаа юм. Алдаж байна шүү.

Энэ мөнгөний бодлого, төсвийн бодлого эд нарыг өргөн барихаас өмнө Валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк бүх эдийн засагчид сууж байгаад үнэлгээ хийж байгаад болно гээд явж байгаа ийм дүр зураг бол гадаад зах зээлтэйгээ холбогдож явж байгаа төлөвлөлт юм шүү. Эцэст нь гээд хэлэхэд бид нар дөнгөж саяхан л 4 жилийн өмнө дефолт зарлалаа гээд л байсан шүү дээ, нөөц байхгүй. Энэ дефолтоос гарах ямар арга замаар гарсан юм бэ гээд тэгэхээр ерөөсөө өрийн дахин санхүүжилтээр гарсан байхгүй юу. Бид нар нэг үе их хэмжээний төлөлт хийх юмыг чинь хойшоо ингээд алгуураар ингэж хийж өгсөн, хойшоо шидсэн. Шинээр бонд гаргаад л, эх үүсвэрээр нь өмнөх бондоо төлөөд л, дахиад л шинээр бонд гаргаад л улам хямдруулаад л яваад байгаа энэ процесс чинь өөрөө дахин санхүүжилт байхгүй юу.

Энэ дээр чинь эх үүсвэр хэрэгтэй юм. Ингэж байж гадна талд зах зээлийн бенчмаркет тогтож байж, гаднын хөрөнгө оруулагчид наашаа сонирхдог, мөнгөө хийдэг, үр дүнд нь Монголын эдийн засаг тэлдэг. Энэ зөвхөн шууд хөрөнгө оруулалт гэдэг байдлаар бид нар харж болохгүй. Санхүүгийн хөрөнгө оруулалт гэдэг чинь бол бодитойгоор cash оруулаад, тэгээд манай бондыг авна уу, Улаанбаатарын бондыг авна уу, компаниудын бондыг авна уу энэ бүх бонд дотор чинь дамжиж эдийн засаг тэлж явдаг. Ийм ч болохоор ингээд зээлжих зэрэглэлүүд нь өсчхөөд, одоо ингээд тэлэх боломж байна гээд тэгэнгүүт хөөе байж байгаарай, наадхаа боль, бүгдээрээ сайхан ингээд хумья гэсэн байдлаар явах нь өөрөө алдаа болно шүү гэдгийг зүгээр мэргэжилтэн хүний зүгээс хэлж байгаа юм шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн, сайд Одбаярт микрофон өгье.

Э.Одбаяр: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ төхөөрөмж нь ажиллахгүй юм. Тэгээд горимын санал гаргах гэхээр энэ зөв ч юм шиг, буруу ч юм шиг, тэрийгээ улс төржүүлээд. Тэгээд Сангийн сайдтай холбоотой асуудал, Сангийн сайдаас оруулсан төсвийн асуудал яригдаж байдаг. Тэгээд дотроо ойлголцоогүй байгаа юм шиг ийм сэтгэгдэл төрүүлээд байдаг. Энэ дээр хэдүүлээ бас жоохон бодолцмоор юм шиг байх юм. Саяын тэр 30 дугаар горимын, 30 дугаар санал дээр миний төхөөрөмж ажилласангүй. Тэгээд гар өргөөд байдаг өгдөггүй ийм л юм болоод байна. Тэгээд дараагийн санал хураалт хийхээсээ өмнө энэ асуудлаа дахин санал хураалт явуулж саяын 30 дугаар санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэж санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Одбаяр сайд саналаа өгч чадаагүй 30 дугаар асуудлаар горимын санал гаргаж байна. Энэ горимын санал гаргасан талаараа гадна талд хэвлэл мэдээлэлд горимын санал гаргасан хүмүүс өөрсдөө тайлбаруудаа өгцгөөгөөрэй. Яагаад горимын санал гаргаж байгаа талаараа. Техниктэйгээ харьцаж чадахгүй, хоцорсон,

саналаа өгч чадаагүйн улмаас гэдгийгээ тайлбарлахгүй бол. Их Хурлын дэд, Их Хурлын дарга индэр дээр суучхаад л, хүн рүү харж байгаад л, нэр цохож горимын санал гаргуулаад байгаа юм шиг ойлголт өгч, юм ярих нь зохисгүй юм гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Энэ Одбаяр сайдын гаргасан горимын саналаар 30 дугаар саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулна. Тэрний өмнө одоо 7 санал хураалт үлдсэн байна. Санал хураалтыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Ил санал хураалтыг төхөөрөмжөөр юм уу, гар өргөж санал хураалгаж болно гэсэн заалт байгаа. Тийм учраас одоогоос эхлээд дахиж төхөөрөмжтэй холбоотой маргаан гаргахгүйн тулд үлдсэн санал хураалтыг гар өргөж санал өгнө.

Ингээд Одбаяр сайдын гаргасан горимын саналаар 30 дугаар саналын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гар өргөнө. 96 гишүүн ирцэд бүртгэлтэйгээс 64 гишүүн дэмжсэн байна. Дэмжээгүй гишүүд гараа өргөчихье. Зураг дарж авах нь зүйтэй. Олонх дэмжсэн, санал хүчингүй боллоо.

Тэгвэл 30 дугаар саналыг Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 гишүүн дэмжиж, олонх дэмжсэн тул санал дэмжигдлээ.

31 дэх санал хураалт. Санал хураалт эхлүүлье. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хурааж байгаа. 65 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

32. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дэх Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын 5.1.5 Эрсдэлийн санд тусгагдсан 53,562.6 сая төгрөгөөр 5.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураа. Санал гаргасан гишүүн Түвшин тайлбар өгнө.

Б.Түвшин: Энэ асуудал төсвийн орлого, зардалд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй. Ер нь ЭМД-ын сангаас гарах тусламж, үйлчилгээний санхүүжилтээс Эрсдэлийн санг нь дотор нь байгуулчхаж байгаа юм байна лээ. Тэгэхээр нөгөө яаралтай тусламж, үйлчилгээний санхүүжилтийг жилийн эцсээр авах болохоороо бөөн төвөгшилтэй болоод цаг тухайд нь авч чадахгүй ийм асуудал үүсэж байгаа. Ер нь цаашдаа энэ эрсдэлийн санг нэмж байгуулаад, үндсэн зардал дотроос нь хасдаггүй байх ийм саналтай байгаа. Тийм учраас эрхэм гишүүддээ хэлэхэд энэ ЭМД-аас гарах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг яаралтай цаг хугацаанд нь шийдэх ийм санал байгаа. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр шийдсэн ийм санал байгаа юм шүү. Тийм учраас энэ саналыг дэмжихгүй байж, гараа өргөхгүй байж тусалж өгөөрэй гэж.

Д.Амарбаясгалан: 32 дугаар санал Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 6 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

33. Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.33. “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/, хэрэгжих хугацаа 2023-2026 он, төсөвт өртөг 135,583.3 сая төгрөг, санхүүжих дүн 34,278.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,900.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Улаан-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам 2.1 км /Увс, Улаангом сум, 5-р баг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,400.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,400.0 сая төгрөг, Төв цэнгэлдэх

хүрээлэнгийн автомашины зогсоол /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 3,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэн. Төсвийн байнгын хорооны саналыг дэмжээгүй саналыг, дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүдийн олонх дэмжээгүй байна. Санал дэмжигдсэнгүй.

34.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал”-ыг 9,278.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр XIX.1.9.“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2026, төсөвт өртөг 35,943.6 сая төгрөг, санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 9,278.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан. З.Мэндсайхан гишүүн чөлөөтэй байгаа. Энэ гаргасан саналаа татах саналыг бичгээр ирүүлсэн тул санал татагдлаа.

35.Төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 32,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 200 ор, /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 4,510.1 сая төгрөг, санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин. Түвшин гишүүн микрофон өгье.

Б.Түвшин: Энэ саналыг татаж авч байна.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

36.Төслийн 2 дугаар хавсралтын XYI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 6,200.0 сая төгрөгөөр бууруулж, Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 13,500.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,500.0 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 5,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,700.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдийн олонх дэмжсэн байна. Санал дэмжигдсэнгүй.

37.Төслийн 2 дугаар хавсралтын XYI.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 14,700.0 сая төгрөгөөр бууруулж, Үерийн хамгаалалтын далангийн засвар шинэчлэлт /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/, төсөвт өртөг 7,321.4 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг, Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто зам II үе шатны ажил /Дархан-Уул/, төсөвт өртөг 9,723.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,500.0 сая төгрөг, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул/, төсөвт өртөг 17,147.9 сая төгрөг, санхүүжих дүн 5,700.0 сая төгрөг, Өргөх насос станцын тоноглол /Дархан-Уул, Дархан сум/, төсөвт өртөг 8,535.4 сая төгрөг, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын

Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Гишүүдийн олонх нь дэмжсэн санал өгч, гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй.

38.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ1.1.1.19.Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66км /Баруун бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 163,736.3 сая төгрөг, санхүүжих дүн 32,747.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,957.9 сая төгрөгөөр бууруулж, ХҮ1.1.1.70.Хар үзүүр, Ховд голын төмөр бетон гүүр, 217 у/м, хатуу хучилттай авто зам, 0.4 км /Баян-Өлгий, Алтанцөгц сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 8,913.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,706.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,957.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Аубакир. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тэгээд л нэг л зарчмаар явсан нь дээр биз дээ Байнгын хороо. Тоолчих. Татгалзаж байгаа гишүүд гараа өргөе. 60 гишүүн дэмжсэн юм уу? Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 60 гишүүн дэмжсэн байна, 19 гишүүн дэмжээгүй байна. Тэгэхээр Байнгын хорооны санал дэмжигдсэн гэсэн үг.

Ингээд зарчмын зөрүүтэй томъёоллоор санал хурааж, Пүрэвдорж гишүүн горимын санал гаргана.

Б.Пүрэвдорж: Өчигдөр 2.3 дугаар санал дээр буюу би өөрөө энэ оюутны дотуур байрны барилга Ховд аймагт барих тэрнээсээ хасаад дотор нь санхүүжих дүн гүйлгээд Ховд шинэ үйлдвэрлэлийн паркт зориулж бас нэг хамгийн анхны цэвэрлэх байгууламж Ховд аймагт байгуулагдаж байгаа. Энийг бол Бямбацогт гишүүн бол дандаа ярьж явдаг. Тэгэхээр санаачилсан. Тэгээд энэ нэг бас нөгөө өчигдөр юуны Энхбаяр сайд болохоор өөрийнх нь төсвөөс хасаж байна гэж буруу ойлгоод, хүмүүст буруу ойлгогдоод ингэчихсэн. Тэгээд ер нь бол энэ бол маш чухал хэрэгцээтэй төсөл байгаа юм. Тэгээд энэ дээр зөвхөн санхүүжих дүнг өөрчилж байгаа болохоос биш ямарваа нэгэн төсөвт өртөг болон шинээр нэмж байгаа асуудал огт байхгүй учраас нэгэнт санал хураалгачихсан учраас энэ саналыг хүчингүй болгож байж, цаашаа нөгөө нэг чиглэл Төсвийн байнгын хороонд өгдөг. Тийм учраас та Их Хурлын дарга энэ саналыг хүчингүй болгох санал хураалт өгөөч гэж. 2.3. Тэгээд энэ дээр тэгээд буцаагаад. Тэгээд дахиад Байнгын хороо руу чиглэл өгүүлэх ийм саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүний гаргаж байгаа санал чинь уг нь Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал уначихсан юм тийм ээ. Тэгэхээр тэр саналыг босгож өгөөч л гэдэг горимын саналыг өчигдрөөс хойш гаргаж байгаа юм. Энэ дээр Тамгын газраас тайлбар өгөх үү? Өчигдөр санал хураалт дээр явж байгаад горимын санал гаргахад нь горимын санал өгөлгүйгээр урагшаа явчихсан санал байгаад байгаа юм. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон өгье.

Б.Баасандорж: Баасандорж. Саяын асуудлаар тодруулга хийе. Саяын Пүрэвдорж дэд даргын гишүүний хэлж байгаа санал бол өчигдөр 2.2.3 дахь санал чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураагдсан, 46,1 хувийн дэмжлэг авсан буюу энэ санал дэмжигдээгүй. Дэмжсэн санал чуулганы нэгдсэн хуралдаанаар унасан. Тэгэхээр одоо Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Төсвийн байнгын хороонд чиглэл өгөх болон дахин горимын саналаар бол хураалгах асуудал байхгүй. Дэгээрээ зохицуулагдаагүй, ийм зүйл бол боломжгүй Дэгийн хуулиар.

Д.Амарбаясгалан: Яах вэ ингэх юм байна. Батсуурь гишүүнд микрофон өгье. Өөр асуудлаар тийм ээ? Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Даргаа энэ Төсвийн байнгын хорооны дэмжигдээгүй саналын 17-д Золжаргал гишүүний гаргасан саналыг дахин авч үзэхгүй бол болохгүй байгаа юм. Яагаад вэ гэхээр энэ салбар хоорондын баланс алдагдаж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт тойргийн гишүүдийн бүсийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээний энэ бүтцэд зориулсан эх үүсвэрээс зориудаар 5 тэрбумыг буулгана гэж ийм байж бол болохгүй. Энэ үндсэндээ парламентын түүхэнд ийм зүйл гарч байгаагүй. Яагаад вэ гэхээр хатуугаар хэлэх юм бол энэ чинь бие биеийнхээ зүйлийг далайн дээрэмчин шиг ингэж дээрэмддэг болох нь байна шүү дээ. Тийм учраас нэг талаасаа тийм. 2 талаасаа энэ бол өөрөө салбар дотроо юм уу, гишүүн хоорондоо өөрийнх нь эх үүсвэр нь хоорондоо гүйж байгаа асуудал огт биш учраас энэ асуудлыг Золжаргал гишүүнээр саналыг нь татуулах юм уу эсвэл горимын саналын дагуу хүчингүй болгож, дахин санал хурааж өгөхийг хүсэж байна. Энэ бол өөрөө парламентын түүхэнд өмнө нь бараг гарч байгаагүй үзэгдэл гэж ингэж ойлгож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батсуурь гишүүний хэлж байгаа саналыг санал гаргасан гишүүн Золжаргал гишүүн үг өгье.

Ж.Золжаргал: Өнөө өглөө нэг санал дээр хүчингүй болгох горимын санал гаргаад санал хураасан шүү дээ. Тийм байдлаар хүчингүй болгох горимын санал гаргаж өгнө үү гэж хүсэж байна. Энэ өөрөө би дураараа гаргасан санал биш л дээ. 23 онд түрүүчийн Засгийн үед цахим аймаг гэдэг тийм их аятайхан хөтөлбөр гаргаад, зарим нь их дажгүй урагшаа явчихсан, зарим нь бол хоцорчихсон юм байна лээ. Зарим нь зайлуул мөнгө төгрөг байхгүй гээд. Тэгээд тэр яаман дээр байгаа судалгаа байна, бас би хэд хэдэн газар орж үзсэн.../үг тасрав/

Д.Амарбаясгалан: Үгүй ээ үгүй, Золжаргал гишүүнээ.

Ж.Золжаргал: Тэгээд орсон юм. Тэгээд буруу эх үүсвэрээс хассан байвал, горимын санал гаргаад.../үг тасрав/

Д.Амарбаясгалан: Өглөө Галбадрах гишүүн өөрийнхөө гаргасан саналыг татах санал гаргасан учраас уг саналаар нь санал хураачихсан байсан учраас санал хураалтыг нь хүчингүй болгох ажил явсан байхгүй юу. Тэгэхээр өөрөө гаргасан саналаа татахаар байгаа юм уу гэдэг асуулт л явж байна л даа.

Ж.Золжаргал: Саналаа татъя тэгвэл, татлаа.

Д.Амарбаясгалан: Хэддүгээр санал билээ?

Ж.Золжаргал: 17. Гуравдугаар хэлэлцүүлгээс 17 дугаар саналыг татъя.

Д.Амарбаясгалан: Эхлээд Золжаргал гишүүний 17 дугаар санал өчигдөр санал хураалт явагдсан. Гэхдээ энэ салбар дундын асуудал буюу нэг салбарын сайдын багцаас Байнгын хороон дээр санал гаргаад, нөгөө сайдын багц руу татсан асуудал нь өргөн барьсан төслийнхөө үзэл баримтлалтай нийцэхгүй байна, салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын асуудал дээр хүндрэл үзүүлж байна гэдэг байдлаар сайд нар өчигдөр ярилцсан, хоорондоо уулзаж ярилцсан байна. Ингээд санал гаргасан гишүүн Золжаргал

саналаа татаж байгаа учраас 17 дугаар саналыг, дэмжигдсэн саналыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал, үгүй ээ үгүй адилхан, өглөө бас тэгсэн учраас горимын саналаар хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явъя. Хүчингүй болгоё гэж дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Гишүүдийн олонх нь дэмжлээ. Ингээд 17 дугаар санал татагдлаа.

Бейсен гишүүн горимын санал. Хэддүгээр асуудал дээр гэдгээ хэлээрэй.

Б.Бейсен: Энэ төслийн 2.3-д байгаа ажлын хэсэг дэмжсэн санал дээр миний кноп ажиллаагүй учраас дахин санал хураалгаж өгнө 1 дүгээрт.

2 дугаарт энэ 38 дугаар санал чинь урьд нь энэ батлагдсан төсөв энэ сая ажлын хэсэг.../үг тасрав/

Д.Амарбаясгалан: Төслийн 2.3. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг өчигдөр чуулганы санал хураалт, хуралдаан дээр санал хураалт яваад 46,1 хувиар дэмжигдээгүй. Тэгээд уг санал хураалтын дараа хэд хэдэн гишүүд горимын санал гаргаж, дахин санал хураалт явуулах асуудлыг хөндсөн боловч горимын санал өгөлгүйгээр урагшаа явсан байгаа. Энэ асуудлыг нийт санал хураалтын төгсгөлд ахиж авч хэлэлцэнэ гэж хэлээд, урагшаа явсан байгаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Бейсен гишүүн 2.3-ыг дэмжигдээгүй саналыг хүчингүй болгож санал хурааж өгөөч гэдэг горимын санал гаргаж байна. Бейсен гишүүний гаргаж байгаа горимын саналаар 2.3 дахь санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсэж байна. Санал хураалт. Гишүүдийн олонх дэмжсэн тул санал хураалт хүчингүй боллоо.

Тэгээд 2.3 дахь санал дахин санал хураагдана. Ажлын хэсгийн гаргасан Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна. Танхимд байгаа гишүүдийн 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн даран 71 дүгээр зүйлийн 71.14-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзсэн. Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд буцааж байна. Нэг цагийн хугацаатай.

11.29 цаг

Хоёр.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Дараачийн асуудалд орно. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Одоо Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт явна шүү. Төхөөрөмжөөр явах уу?

Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хурааа. Гар өргөе. Татгалзсан гишүүн байна уу? Алга байна. Танхимд байгаа гишүүдийн 100 хувийн саналаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. 1 гишүүн Түвшин гишүүн татгалзсан байна.

Хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хурааж байгаа юм. Түвшин гишүүн, Ганбаатар гишүүнээс бусад гишүүд дэмжиж байна. Татгалзсан дээр Уянгахишиг гишүүн нэмэгдэж байна.

3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураана. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. Ганбаатар, Түвшин, Уянгахишиг, Золж..., Уянгахишиг, Амарсайхан, Батлут, Алтаншагай, Энхтүвшин зэрэг гишүүд дэмжье, Алтаншагай, Амарсайхан дэмжиж байгаа юм байна. Бусад нь дэмжээгүй байна. 3 гишүүн дэмжээгүй байна. Гар өргөөгүй байна. Батлут гишүүн дэмжсэн байна.

4.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураана. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. Санал хураалт. Би дэмжихгүй, татгалзаж байгаа гишүүдийг л дахиж тоолуулахгүйгээр нэрийг нь дурдаж байгаа юм. Зөв байх гэж бодож байгаа юм. Түвшин гишүүн, Ганбаатар гишүүн, Уянгахишиг гишүүн, Энхтүвшин гишүүн 4 өргөөгүй байна. Даваагийн Цогтбаатар гишүүн дэмжээгүй байна. Бусад гишүүд дэмжсэн байна, олонх дэмжсэн.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

11.33 цаг

Одоо Төсвийн байнгын хороо хуралдаж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах тул чуулганы хуралдааныг 12 цаг 30 минут хүртэл, Хууль зүйн байнгын хороо байгаа. 12 цаг 30 минут хүртэл түр завсарлууллаа.

*2024 оны 11 дүгээр сарын 01, Баасан гараг,
Төрийн ордон "Их хуралдай" танхим
14 цаг 46 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Амарбаясгалан: Гишүүдэд өдрийн амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 01-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, тодорхой асуудлын хүрээнд хоёр дахь хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.4-т заасны дагуу/

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд, хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулна. Төслүүдийг тодорхой асуудлын хүрээнд хоёр дахь хэлэлцүүлэгт дахин бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Баясгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хуралдаанаараа явуулж, зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлтгэн Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын 2024 оны 10 сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулиудын төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Хууль зүйн байнгын хорооноос ирүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзэн Төсвийн байнгын хороонд буцаасан юм.

Төсвийн байнгын хороо 2024 оны 11 сарын 01-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулсан бөгөөд Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан Дархан-Алтанбулагийн чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113,1км, гүүрэн байгууламж, 855 метр урттай, Төвийн бүс гэсэн төсөл арга хэмжээний санхүүжүүлэх дүнг бууруулж, уг эх үүсвэрээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцад хамаарах шүүхийн байрууд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмжтэй холбоотой болон Улсын ерөнхий прокурорын зарим зардлыг нэмэгдүүлэх саналтай холбогдуулсан зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал зардал нэмэгдүүлэх саналыг дэмжиж байна, харин санхүүжилтийн эх үүсвэрийг томоохон бүтээн байгуулалтын ажлын нэг болох Дархан-Алтанбулагийн чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөлийн ажлын санхүүжилтийг бууруулан гаргаж байгааг өөрчлөх боломжтой эсэх талаар санал хэлсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу дахин явуулсан Байнгын хорооны санал, дүгнэлтийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дархан-Алтанбулагийн чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Төсвийн хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүнд баярлалаа. Төсвийн төслийн тодорхой асуудлын хүрээнд дахин явуулсан хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь энэ хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлтсийн дарга Даваасүрэнгийн Эрдэнэсамбуу танилцуулна. Ажлын хэсгийн 1 дүгээр индэрт урьж байна.

Д.Эрдэнэсамбуу: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо тодорхой асуудлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, олонхын дэмжлэг авсан саналд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.13 дахь заалтын дагуу тус хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71-ийн, 71 дүгээр зүйлийн 71.14-д заасны дагуу Төсвийн байнгын хороо тодорхой асуудлын хүрээнд төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр явууллаа.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр 91,475.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2025 онд 33,769.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд шинээр нэмэх, хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр, Улсын ерөнхий прокурорын урсгал зардлыг 1,182.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналууд олонхын дэмжлэг авсан. Мөн төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 39,951.5 сая төгрөгөөр бууруулах санал дэмжигдсэн болно.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед олонхын дэмжлэг авсан санал нь ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагын болон алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батнямын Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Төсвийн байнгын хорооноос тодорхой асуудлын хүрээнд гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. 1 санал хураалт байгаа. Ирц санал хураалт явуулахад хангалттай байгаа юу? Төхөөрөмжөөр ирцийн санал хураалт нэг явуулаадахъя. Санал хураалт. 99 гишүүн ирцэд бүртгэлтэй 49 гишүүн, 50 гишүүн санал хураалтад оролцсон байна. Тэгэхээр санал хураалт явуулах боломжтой ирц гэж үзье. Төсвийн байнгын хорооны тодорхой асуудлын хүрээнд гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын ХҮ1.1.1.7.Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 630,587.5 сая төгрөг, санхүүжих дүн 104,646.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 39,951.5 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх. Үүнд:

-Төслийн 2 дугаар хавсралтын ХХҮ.3.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 15,275.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

-Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн анхан шатны шүүхийн шүүхийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,801.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,120.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Өмнөговь аймаг дахь шүүхийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 4,452.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,780.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга /Дархан-Уул, Дархан сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 12,320.0 сая төгрөг, санхүүжих дүн 4,928.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Багануур дүүрэг дэх шүүхийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 8,674.7 сая төгрөг, санхүүжих дүн 3,469.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2013-2026 он, төсөвт өртөг 44,552.4 сая төгрөг, санхүүжих дүн 15,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх;

-Улсын ерөнхий прокурорын урсгал зардлыг 1,182.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Даваагийн Цогтбаатар, Пүрэвжавын Сайнзориг. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байгаа. Тэгэхээр Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтыг гар өргөж явуулна. Санал хураалт. Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу? 1 гишүүн байна. Хаана байна вэ? Мөнхбаясгалан гишүүн, Ундрам гишүүн, Батжаргал гишүүн 3 татгалзсан. 52 гишүүн дэмжсэн, 4 гишүүн татгалзсан. Санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулиар хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал гэж 3 институт байдаг. Шүүх засаглалын эрх хэмжээг тогтоохдоо Шүүхийн тухай хуулийн тодорхой зүйл, заалтаар тогтоодог. Ялангуяа төсөв батлах процесс нь өөрөө Шүүхийн тухай хуулийн 46.8-ын дагуу Хууль зүйн байнгын хороогоор хянагдсан төсвийг Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барина гэсэн заалт хэрэгждэг байх учиртай. Тэгээд энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүднээс Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүд бас санал гаргаж, энэ төсвийн батлах процесс дээр удаа дараагийн санал гаргасны үндсэн дээр Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороо албажуулж хэрэгжүүлээ.

Цаашдаа Шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлж, удаа дараагийн өргөн барих улсын төсөвтөө энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байхыг Засгийн газар, Сангийн яаманд бас үүрэг чиглэл болгож өгч байна. Төсвийн байнгын хорооноос тодорхой асуудлын хүрээнд гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

15.02 цаг

Дөрөв. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд орёе. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлэг

явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 207 дугаар захирамжаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсэг болон гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батнямын Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 13 гишүүн асуулт асуухаар нэр ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Юун дээр асууж байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: Төсвийн хүрээний мэдэгдэл. Асуултгүй байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу, дахиад өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр сүүлийн олон хоногуудад төсвийн үйл явц буюу төсвийг хэлэлцэх энэ үе шатууд эд өрнөж байна. Тэгээд ер нь бол би анх удаа сонгогдсон гишүүн маш их юм суралцаж, ажиглаж, өөрийн хэмжээнд дүгнэлт саналаа дотроо боловсруулаад явж байна. Тэгэхээр хамгийн гол суурь асуудал юу вэ гэхээр анх энэ төсвийн хэлэлцүүлгийн нэгдүгээр үе эхэлж байхад хэлж байсан. Юу вэ гэхээр яг зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг хийхгүй бол цаг нь нэлээн оройтсон юм болов уу гэж гэж бодож байна. Энэ танхимд нэг хэлэлцүүлэг өөр. Төсвийн байнгын хороон дээр нэг өөр. Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороон дээр нэг өөр. Сошиал ертөнцөд нэг өөр ийм хэлэлцүүлгүүд давхар явагдаж байна гэж харж байна.

Тэгэхээр угаасаа төсвийг анхнаас нь боловсруулахдаа хангалттай цаг өгөөд, 2 дугаарт Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэж байдаг. Үндэсний аудитын газар гэж байна. Энэ 2 газраас маш том, маш олон асуудал маш олон бодлыг дагуулсан дүгнэлтүүд гаргаад байна. Энд гаргасан дүгнэлтийг тухайн асуудал дээр цаг гаргаж байгаа гишүүд эсвэл улс төр хийх гэсэн гишүүд хараад өм цөм энд тэнд Байнгын хороон дээр юм уу, энэ чуулган дээр ярьж, давхар явж байна. Тэгэхээр яг миний зүгээр харах гээд байгаа гол зорилго юу вэ гэхээр асуудлыг шийдэхийн төлөө явж байна уу, улс эх орон, нийгмийн төлөө хөгжлийн төлөө явж байна уу, зөвхөн улс төрийнхөө өөрийн имижийг бүрдүүлэхийн төлөө янз бүрийн тоглолтууд хийж байна уу гэдгийг анхааралтай ажиглаж байна.

Тэгэхээр ерөөсөө төсвийн үйл явцад цаг хугацаа шаардлагатай байна. Маш их ажилласан энэ ЗГ-аас оруулж ирсэн төсвийг Их Хурлын гишүүд нэг худлаа, үнэн ирц бүртгүүлээд орж байгаа, ороогүй оромдоод, Байнгын хороодоор явсан болоод, чуулган дээр хэлэлцсэн болоод явж байгаа нь өөрөө эргээд Их Хурлын гишүүдийн нэр хүндэд ч гэсэн маш их ийм асуудлуудыг авчирч байна гэж харж байна. Тэгэхээр удаа дараа хэлж байна. Нэг асуудлыг нэг гишүүн, жишээлбэл инфляц, эдийн засгийн өсөлт дээр нэг гишүүн гэхэд л нэгээс доошгүй удаа бараг хэлж байна. Энэ асуудлыг магадгүй 10-аас доошгүй гишүүн удаа дараа давтамжтай хэлж байна. Энийг би дахиад хэлье. 2026, 27 төсвийн хүрээний мэдэгдэл дээр инфляцыг ирэх онд 5 хувь, тэрний дараагийн жил 4 хувь гээд тооцчихсон. Энийг бол би биелэхэд хүнд гэж итгэсэн хэвээр байна.

Яагаад вэ гэхээр нэг талдаа төсөв тэлж байна эдийн засаг хална, нөгөө талдаа бид нар мөнгөний болон төсвийнхөө уялдаатай бодлогыг дандаа алдаж явж байна. Төсөв тэлж байна, мөнгөний бодлого хэрэгжих орон зай хумигдаж байна. Тэгэхээр нэгэнтээ бид нар төсвийн тодотголоороо буюу ээлжит бус чуулганаар Төсвийн тогтвортой байдлын хуулийн 6.1.3-ыг өөрчлөөд, зардлыг ДНБ-тэй харьцуулахад 30 хувиар өсөхгүй гэж тооцдог байснаа үгүйсгэсэн бол ядаж нийт төсвийнхөө энэ хэмжээг 35 хувиас хэтрүүлэхгүй байх ийм саналыг оруулмаар байгаа юм. Төсвийн тогтвортой байдлынхаа хуулийг эргэж харах, мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Үндэсний аудитын

газрынхаа хөдөлмөр цаг хугацааг үр ашигтай ашиглая гэсэн гол саналыг тавингаа дахиад энэ асуултаа асуумаар байна. 2026, 2027 онд Төсвийн хүрээний мэдэгдэлд бид нарын тооцож байгаа макро эдийн засгийн үзүүлэлтүүд биеллээ олох магадлал хэр байна вэ? Хэрвээ төсөв орлого хүлээснээр биелэгдэхгүй бол Б буюу өөр option байгаа юу?

3 дугаарт болохоор энэ горимын санал хэлж байгаа Заяабал гишүүнтэй болон бусад Ганзориг гишүүн, бусад гишүүдтэй хамтраад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан тэр тайланг тусгайлан авч хэлэлцдэг ийм цаг үеийг төсөв, төсвийн үйл явц дахь цаглаварт оруулмаар байгаа. Энийгээ бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 дүгээрт гишүүд хурууныхаа хээг уншуулья. Суудлын дугаар гараад, нэр гарахгүй байгаад байна. Нэр өгөх дараалал дээр. Мөнхсоёл гишүүнтэй санал нэг байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд, Сангийн сайд гээд холбогдох албан тушаалтантай ярьсан. Мөн Төсвийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, аудитын байгууллага бүх талын төлөөллийг оролцуулаад энэ онд төсөв баталсны ар дээр ажлын хэсгийг өргөн хүрээгээр байгуулна гэж байгаа юм. Ирэх жилээс 2024 оны ЗГ-ын үйл ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэл, ирэх оны төсөв, мөн төсвийн хүрээний мэдэгдэл зэрэг өргөн барих төслүүдийн цаг хугацааны интервалыг зөв болгохгүй бол харилцан хоорондоо уялдаа холбоо сул байгаагаас хамаараад Улсын Их Хурал, ЗГ-ын үйл ажиллагаа уялдаж явах нөхцөл байдал дээр хүндрэл үүсэж байгаа тал бас байна.

Тэгэхээр энийг ирэх оны 1 сарын 1-нээс өмнө ямартай ч нэг талд нь гаргаж, том зургаар нь нэгдсэн байдлаар зургийг нь гаргаж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тухайлбал 9 сарын 1-нд төсөв өргөн барьж байгаа. 10 сарын 1 хүртэл хэлэлцэж чадахгүй байж байгаа нөхцөл байдал энэ жилийн тухайд ажиглагдаж байна. Бүхэл бүтэн нэг сарыг хангалттай хэмжээнд ашиглаж чадахгүй, энэ хэлэлцүүлэг өргөн хүрээнд явж чадахгүй байгаа байдал нь Улсын Их Хурлыг цаашдаа богино хугацаанд ажиллах, Улсын Их Хурлын гишүүдээс гарч байгаа ажил хэрэгч саналуудыг ажлын хэсэг болон мэргэжлийн Байнгын хороон дээр авч үзэх, санал солилцох тэр боломжуудыг илүү хумьж байгаа ийм дүр зургууд маш тодорхой ажиглагдаж байна гэж байгаа юм.

Мөн үүний хүрээнд төсвийн жилийн хугацаатай холбоотой асуудлыг хүртэл бид Үндсэн хуульд нийцүүлж, асуудлыг хөндөж ярих нь зүйтэй гэдэг байдлаар тал талаасаа санал солилцож байгаа. Шүүмжилж байгаа саналыг бас хүлээж авах ёстой, бодитой гэж үзэж байна. Хариулт өгөх хүн байна уу? Үндсэндээ хариулчихлаа тийм ээ. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна. Алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Надад 2 асуулт байгаа. Хоёулаа Боловсролын сайдад Наранбаяр сайдаа танд. ЗГ-ын тусгай сан энэ удаа ЗГ-ын 22 тусгай санд 11,6 их наяд төгрөг, яах вэ эндээс бид нар нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, эрүүл мэндийн даатгалын сангаа ер нь бол авчих хэрэгтэй. Энэ нийт дүнгийнхээ бараг 90, 92 хувь нь болно гэсэн үг. Тэгэхээр үлдсэн 19 сан дээр 947 тэрбум төгрөг ноогдсон байгаа юм. Гэхдээ эндээс бас нэг сайшаалтай зүйл нь яг энэ жил энэ 19 сан дотроос хамгийн өсөлттэй, бусадтайгаа харьцуулах юм бол ер нь өсөлттэй орж ирсэн 3 сан байгаа юм. Тэр нь бол Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан. Нэг ёсондоо яг хөдөлмөр эрхлэлтийг ерөөсөө дэмжих, тэгээд илүү ур чадвар олгох тэр шаардлагатай санхүүжилтийг хийх. Мөн Боловсролын зээлийн сан.

Тэгэхээр хамгийн үр өгөөжтэй урт хугацаандаа шаардлагатай, үнэхээр цаашаага сайжрах ёстой 3 сан бол яг энэ 3 сан дээр нэмэгдэж орж ирсэнд бол талархалтай хандаж байгаа шүү. Энэ 3 сан нөгөө 19 сангаасаа 546 тэрбум буюу 57,6 хувийг нь эзэлж байгаа юм. Энэ дээр бол Боловсролын сайдад тэр дундаа Боловсролын зээлийн сан бол 51 тэрбумаар, 51 тэрбумаар нэмэгдэж орж ирж байгаа юм. Тэгэхээр энийг маш олон аав, ээж нар, хүүхдүүд, суралцагч, сурагчид сонсож байгаа байх. Боловсролын зээлийн сан бүр илүү томроод орж ирсэн. Монгол улсын ЗГ-ын тэтгэлэг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг, ЗГ-ын гэрээгээр гадаадад суралцах тэтгэлэг, мөн гадаадад суралцах тэтгэлэг энэ 4 категорид 103 тэрбум төгрөг оногдсон байна. Тэгэхээр хамгийн гол нь тэд нарын асуух асуулт нь энэ сонгон шалгаруулалт энэ 100 тэрбум төгрөг зөв хуваарилагдах уу, яг зөв шударга эздэдээ очих уу гэдэг том асуултын тэмдэг байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бас нэг хариулт өгөх ёстой гэж бодож байна.

2 дугаарт бид нарын өнөөдрийн бухимдаад байгаа нэг зүйл бол ер нь төсөв гэдэг өөрөө ард түмний татварын мөнгөнөөс бүрдэж байгаа юм. Тэгэхээр буцаад ард түмэнд үйлчилгээ үзүүлэхэд нь хуваарилагдаж байгаа л хэлбэр. Тэгэхээр энд Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаар бол энэ төсөв орж ирэхээсээ өмнө олон нийтийн хэлэлцүүлэг салбар бүрээр сайн явах ёстой байсан. Тэгээд энэ төсвийн баримт бичгийн 81 дүгээр хуудас дээр байгаа юм л даа. Ер нь яамнуудыг хараад байх юм бол нэг ойролцоогоор 300 санал ирсэн, 40 санал ирсэн, 20 санал ирсэн гэсэн нэг ёсондоо жоохон гурилдсан талдаа л гэж харагдаад байна л даа. Үе үе л тэгж явж ирсэн.

Харин боловсролын салбар дээр энэ дээр цахимаар хэлэлцүүлэг хийгээд 70802 хүнээс санал авсан гэж байгаа юм. 70802 хүн. Би 70 мянган хүнээс санал ирж байсан төсөв салбар ерөөсөө харж байгаагүй л дээ. Тэгэхээр энийг нэг талаасаа сайшаалтай. Гэхдээ энэ хүмүүсийн санал нь тэгээд хэр бодитоор туссан бэ? 1 дүгээрт.

2 дугаарт ингэж 70 мянган хүнээс санал аваад, бодитоор яг төсөв дээр яг тэр хүмүүсийн хүсэж байгаа зүйлийг та өөрсдийнх нь татвар төлөгчдийн мөнгөөр тусгахад бас механизм нь одоо яг таны энэ жишээн дээр хэр ажиллаж байх юм бэ? Энийг бид нар хэрхэн цаашдаа тэгвэл сайжруулах ёстой вэ? Яагаад гэхээр бид нарын олон бухимдал яг үнэнийг хэлэхэд олон нийтийн өөрсдийнх нь хүсэж байсан зүйл дээр тусахгүйд л маш их бухимдлууд яваад байна л даа. Тэгэхээр энэ бол өөрөө төсөв орж ирэхээсээ өмнө олон нийтийн салбарын хэлэлцүүлэг Төсвийн тухай хуулиараа бол нэлээн дэлгэрэнгүй хийж орж ирсэн, орж ирэх ёстой байдаг л даа. Тэгэхээр энийг бид нар тэгвэл цаашдаа яаж сайжруулах вэ? Яаж нэг ёсондоо олон нийтийн тэр хүсээд байгаа зүйлийг төсөв дээрээ тусгаж өгөх ёстой вэ? Тэгэхээр энэ дээр таны байр суурийг энэ 70 мянган хүнээс санал авахад тэд нарын санал туссан механизм яг яаж явж байна вэ, ямар асуудал байгааг та бид нарт бас тайлбарлаад өгөөч. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ Боловсролын зээлийн сангийн асуудал хөндөж байна. Мөн санал асуулгын асуудлыг хөндөж байна. Боловсролын зээлийн сан бол энэ жил нэмэгдэж орж ирж байгаа. Гэхдээ өмнөх жилдээ тэнцчихсэн оюутнуудын дараагийн жилийн бас нэмэгдэл эд нар гээд ингээд ороод ирж байгаа. Жишээлбэл Ерөнхийлөгчийн 2100 чинь 790 орчим оюутан ингээд сурч байна. Жил жилдээ ингээд нэмэгдээд явж байгаа ийм нэг зүйл бий. Мөн 15 жил тасралтгүй багшилсан багш нарын хүүхдүүдийг нэг хүүхдийг нь төрийн зардлаар эрэлттэй, тэргүүлэх магадлан итгэмжлэгдсэн ийм хөтөлбөрүүдэд хамруулах эд нар гээд ийм үйлчилгээний төрөл өөрөө

нэмэгдэж байгаатай холбоотойгоор энэ Боловсролын зээлийн сан дээр ийм боломжууд нэмэгдэж байгаа.

Энэ харин шударга явж байна уу, үгүй юү гэдэг асуудал бол байнгын асуултын тэмдэгтэй ийм зүйлүүд байгаа. Ялангуяа гадаад руу явж байгаа энэ хүмүүс дээр бол энэ нь эргэж ирээд зээлээ төлж байна уу, төлөхгүй байна уу, хэн нь чөлөөлүүлээд, хэн нь ингэдэг юм гэсэн ийм нийгэм дээр бол аягүй тийм бухимдал үүсгээд байгаа нь бол үнэн. Тэгэхээрээ энэ сонгон шалгаруулалтыг хүнээс үл хамаардаг болгохын тулд бид нар өнөөдөр Хүний эрхийн Комиссыг оролцуулсан, холбогдох байгууллагуудыг оролцуулсан ажлын хэсгийг байгуулаад, Улсын Их Хурлын дэргэд байгуулагдсан ажлын хэсэгтэйгээ хамтраад ингээд ажиллахад бэлэн байгаа.

Юуны тухайд бол энэ төсөв хэлэлцэхийн урьд бол ингээд бид ингээд сайтаараа тавихад 70 гаруй мянган хүнээс бол санал ирсэн. 70 гаруй мянган хүнээс. Эднээс ихэнх нь бол цалин өсгөх, мөн боловсролын тэгш хүртээмж буюу сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлээч гэсэн ийм саналууд, мөн тоног төхөөрөмжийн саналууд ингээд байсан. Энэ дээр энэ төсөвт бол энэ жил 90 сургууль, 62 цэцэрлэгийг бол он дамнасан цэцэрлэг, сургуулиудыг ашиглалтад оруулахаар ингэж оруулж ирсэн нь бол бас нэг хэлбэрээр хариулж байгаа хэлбэр юм болов уу гэж бодож байгаа.

Мөн бидний авсан санал бол санал дотор бол 69134 хүүхэд бүрд компьютер, багш бүрд компьютер гэдгийг бол дэмжиж өгөөч гэсэн ийм санал байсан. Энэ саналыг бид бол өргөн барьсан боловч энэ Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шатад бол дэмжигдэж чадаагүй. Энийг бол тэгэхээрээ ирэх жилийн төсөв дээрээ бас тусгаад, мөн гадаадын зээл, тусламжийн ийм байгууллагуудтай ярилцаж байна. Ер нь бол боловсролын тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд энэ цахимжилт бол зайлшгүй шаардлагатай. Энэ хүрээнд бол энэ саналууд орж ирсэн гэж ингэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: Хэдүүлээ төсвөө хэлэлцэж байгаад дундаас нь ингээд төсвийн хүрээний мэдэгдлээ хэлэлцээд эхлэхээр их сонин санагддаг юм байна шүү дээ. Баахан тоо ярьж, ярьж байснаа одоо тэгээд нөгөө хайрцаг хүрээг нь ярих гээд байгаа. Тэгээд энэ сэтгэлгээний хувьд яах вэ их задгайгаас энгийн рүү, энгийнээс задгай руу явж байгаа ч юм уу их тархи толгой дээшээ, доороосоо их сайхан ажиллах л ёстой л юм шиг байна. Ер нь цаашдаа хэдүүлээ төсвийн хүрээний мэдэгдлээ макро эдийн засагчдаа оруулаад, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Монголбанк илүү мэргэжлийнхнийгээ оруулаад 5 сард батлаад, дахиж цааш нь задалдаггүй ийм байдал руу шилжихгүй бол төсөвтөө тааруулж төсвийн хүрээний мэдэгдэл болон бусад хуулиудаа өөрчилсөөр байгаад өнөөдрийг хүрч байгаа юм байна.

Ийм учраас төсвийн яриа ч гэсэн нэг болохоороо макро эдийн засгийн үзүүлэлт яриад байгаа ч юм шиг, нөгөө болохоороо ингээд төсвийн тоо яриад байгаа юм шиг болчхож байна. Ерөөсөө өнөөдөр бид нар төсөв ярьж байхдаа инфляц, тэнцвэржүүлсэн орлого, ДНБ, ЗГ-ын өр, үндэсний нийт бүтээгдэхүүн зэрэг макро хамгийн гол үзүүлэлтүүдээ ерөөсөө ач холбогдол өгөхөө больчихсон. Өнөөдөр хэн, хаана, яаж төсөв тавих гэж байна вэ гэдэг талаасаа уралдсаар байгаад, тэгээд тийм юмаар 3, 4 хоног, хэдэн 7 хоног тархиа угаалгачихсан хүмүүс дахиад макро руугаа гарч ирэхээр их урвуугаасаа яваад байгаа учраас их сонин болдог юм байна. Тэгэхээр ер нь өнөөдрийн ингээд төсвийн үйл ажиллагаа явцыг харж байхад энэ төсвийн хүрээний мэдэгдлийн асуудлыг 5 сардаа

хийдгээрээ хийгээд, мэргэжлийн түвшинд хийгээд дахиад хөдөлгөдөггүй байх зарчим хэрэгтэй байна. Ингэж байж бид нар цаашдаа эдийн засгийнхаа том үзүүлэлтүүдийг зөв удирдах нь.

2 дугаарт энэ төсөвлөлтийн асуудал маш их хэцүү байна. Өнөөдөр төсвийн тухай хэдүүлээ яриад, ялангуяа энэ Сангийн яамны нөхдүүд нөгөө жинхэнээсээ махаа зулгаана гэдэг болж байгаа байх. Энэ чинь аргагүй шүү дээ. Доороосоо баахан хүсэлтүүд ирчихсэн, бүгдээрэнгийнх нь хүсэлтийг багтаахгүй гээд шахаанд орчихсон. Дээрээс нь бас нэг хэдэн нөхдүүд хасаад өгье гээд дээрээс нь тавьчихсан. Тэгээд тэр төсвийн хүрээний мэдэгдэл буюу том тоогоор нь яг зэрэгцүүлээд баталж байгаа учраас том тоондоо багтахгүй том тоогоо өөрчилчихье гээд ингээд төсвийн тоогоо ярьж байгаа үед тогоогоо томсгуулах гээд явж байдаг. Ийм үед яг бид нартай адилхан гацаанд орчхож байгаа Сангийн яамныхан.

Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэсний дараа дээрээс доош нь төлөвлөдөг, ялангуяа боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалахыг ДНБ-ий юм уу эсхүл төсвийн орлогын тодорхой хувь дээр тавиад тэгээд гүйцэтгэлийн үнэлгээг нь гаргаж байж тодорхой хувиар нэмэгдүүлдэг байхгүй бол өнөөдрийнх шиг ингэж булаацалдаж явах юм бол энэ 3 салбар чинь хоцрогдчих юм байна. Ялангуяа энэ боловсрол, эрүүл мэндийнхэн чинь нэрэлхүү ч юм байна. Уралдаандаа төсөв булаацалдаж тавьдаг уралдаандаа муу ч юм байна. Тэгээд хэтэрхий хурдан шаламгай авхаалжтай хөөцөлддөг нь төсвөө өндөр тавиулж яваад, нөгөө гол үндсэн салбарууд маань алдагдаад яваад байдаг.

Өнөөдөр хэдүүлээ тооцъё л доо. Энэ төсвийн зарлагын хэдэн хувь нь боловсролд явж байгаа юм, хэдэн хувь нь эрүүл мэндэд явж байгаа юм. Манай ЗГ-ын хамгийн гол үндсэн үзүүлэлтүүд болох боловсрол, эрүүл мэндийн асуудал төсөв их нэмэгдэхийн хэрээр нэмэгдэж байгаа юу, үгүй юу гэдэг ийм асуудал туйлын хүнд тавигдаж байна. Ийм учраас Сангийн сайдаас асуухад ер нь энэ дээрээс доош нь төлөвлөдөг аргуудыг ямар хүрээнд нэвтрүүлбэл болох вэ? Цаашдаа яаж ингэж булаацалдаж уралдаж тавьдаггүй болох вэ? Олсон бүх мөнгөө хуулийн дээд хэмжээний алдагдал хүртэл зарцуулдаг энэ байдлыг ер нь яаж өөрчлөх вэ гэдэг тал дээр тодорхой хариулт, тодорхой санал өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ бодлогын асуудал л даа. Төсөв ерөнхийдөө 3 үе шаттай төлөвлөлт. Энд Улсын Их Хурал батална, тэгээд дараа нь ЗГ гүйцэтгэлээр хангах ёстой гээд. Төлөвлөлтийн шатад ер нь бид маш өглөө босоод тэр хөл дээрээ босно гэдэг шиг л ерөөсөө бүх хуульчлагдсан байдаг бүх процесс. Бүх процесс хуульчлагдсан, хязгаарууд хуульчлагдсан ийм байдаг. Тийм учраас төлөвлөлтийн шатад одоо ингээд бид 11 сарын 15-нд төсвөө батлаад л, 16-наас бид хойтонгийнхоо төлөвлөлтийг хийж эхэлдэг юм байгаа юм. Тэгэхээр шат шатандаа төлөвлөлтөөр орж ирж байгаа энэ Төсвийн хууль Их Хурал дээр хэлэлцэхдээ тодорхой хэмжээний өөрчлөлтүүд орох гээд байдаг бас ийм зүйлүүд байдаг.

Дараа нь гараад төсвийг хэрэгжүүлэх шатанд ч бас эрсдэлүүд тодорхой хэмжээнд гардаг. Тэгэхээр түрүүн Улсын Их Хурлын дарга бас хэллээ. Ер нь бид нар эргэж харах яг энэ хуульчилчихсан байгаа яг шат шатны процессуудыгаа илүү их илүү ил тод, тэгээд маш тодорхой, ойлгомжтой болгох ер нь шаардлага байгаа. Тэгэхээр төсвийн реформ гэхээр бид ингээд нэг цаг хугацааг нэг нааш нь, цааш нь болгосноор болчихно гэж бас хязгаарлаж ойлгож болохгүй. Төлөвлөлтийн шатад, хэлэлцэх шатад бид маш нарийвчилж тодорхойлж оруулах, шинэчлэх зүйлүүд маш их байгаа. Та бүхэн маань шинэ Их Хурал энийг эхний энэ төсвийнхөө томоохон хэлэлцүүлэг дээр их харж байгаа байх. Түрүүн Мөнхсоёл

гишүүн ч бас хэллээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ач холбогдлыг бас илүү их илүү тодорхой болгох, ач холбогдол өгөх, тэрийг нь хүндэтгэлтэй хандаж, төлөвлөлтийнхөө шатад, хэлэлцүүлгийнхээ шатад ч хэрэгжүүлэх гээд нэлээдгүй тийм өөрчлөлтүүд хийх шаардлагууд бол байгаа.

Тийм учраас энэ бүхнийг бүгдээрээ хамтраад ингээд хийгээд явъя. Түрүүн Их Хурлын дарга хэллээ. Төсөв батлагдсаны дараа томоохон ажлын хэсэг гаргаад ингээд ажиллаад явъя гэж байна. Тэгээд Түвшин гишүүн сая төсвийн хэлэлцүүлгийн үед ажлын хэсэгт орж ингэж ажиллалаа. Ямар зовлон байдаг юм, сая ер нь аягүй тодорхой хэллээ. Маш сайн ойлгосонд баярлалаа. Тийм. Тэгээд энэ өөрчлөлтүүд дээр хамтраад ажиллаад явъя.

Д.Амарбаясгалан: Тэгээд Жавхлан сайд минь энхийн цагт хөлс их гаргавал дайны цагт цус бага гаргана гэж ЗГ энэ тооцох, төсөвлөх, төлөвлөх зүйл дээрээ онцгой сайн анхаарч ажиллаарай. Улсын Их Хуралтайгаа хамтарч ажиллаад энэ цаг хугацаа энэ графиктай холбоотой цаг хугацааны интервалтай холбоотой олон асуудлыг нэг мөр цэгцлэх тал дээр анхаарахгүй бол дараа жилийн өдийд энэ Улсын Их Хурал яг өнөөдрийн тайлбаруудыг хэлж байгаа ЗГ, Сангийн яамны төсвийг батлахад асар их хүндрэл учирна гэдгийг өнөөдөр зориуд хэлэх нь зүйтэй. Цаг хугацаанд шахагдаад л Улсын Их Хурал өнөөдөр зарим, зарим засчихмаар зүйлүүдээ хүртэл засаж чадахгүй ард нь гарч байгаа гэдгийг та бүхэн зөв ойлгох хэрэгтэй.

Зайлшгүй шаардлагатай эрсдэлд орвол улсын төсөв задрах эрсдэлтэй томоохон заалтууд хүртэл өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд дэмжихгүй унагаах тохиолдлууд хүртэл өнгөрсөн хугацаанд гарч байна. Тэгэхээр хэдүүлээ энэ бие биедээ цаг үед нь таарсан тайлбаруудыг хэлэхгүйгээр дахиад ийм асуудал үүсгэхгүй. 26-аас 27 оны төсвийн хүрээний мэдэгдэл ирэх хаврын чуулганаар ороод батлагдана. Тэр хүрээн дотроо улсын төсөв өргөн баригдана. Дахиад улсын төсөв батлагдсаны араас төсвийн хүрээнд өөрчлөлт оруулах асуудал яригдахгүй гэх мэт зарчмын асуудал дээр маш сайн хариуцлагатай хандах ёстой шүү.

Энэ удаагийн шинэ Их Хурал анхны төсөв баталж байгаа цаг хугацаа орон нутгийн сонгуулийн давхардсан нөхцөл байдал гээд маш олон зүйлээс үүдээд өнөөдөр ийм хүндрэлтэй нөхцөл үүссэнийг бид аль, аль талдаа анхаарч ойлгож байгаа учраас өнөөдөр ингээд ЗГ-ынхаа өргөн барьсан төсөл дээр төвлөрч яриад, ард нь гарч байгаа. Гишүүд бас энэ дотор бухимдалтай байгаа. Тэрийг бас ойлгож байна. Гэхдээ өнөөдөр бид ийм нөхцөл байгааг бүгд өөрсдөө харсан учраас харин богино хугацаанд хамтдаа засаж, нэг мөр болгохын төлөө анхаарлаа хандуулах нь зөв юм гэсэн ийм байр суурийг Их Хурлын зүгээс байнга илэрхийлж явна шүү гэдгийг хэлье. Ингээд Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Би уг нь нөгөө бас нэг зарчмын зөрүүтэй 2 санал гаргасан чинь тэгээд энэ дэгээс болоод Төсвийн байнгын хороо руу шууд өгчихсөн чинь тэнд Ажлын хэсэг нь хэлэлцээд, дэмжигдэхгүй байнгуут дараагийн шатаар хэлэлцэхгүй болчихдог юм байна. Тийм учраас хэнээс ч асуух юм би сайн ойлгохгүй л байна. Би уг нь энэ аудитын дүгнэлтийг уншаад л, ингээд эндээс л болохгүй, бүтэхгүй гэж бичсэн юмыг нь гаргаж ялгаж авч байгаад л, энийгээ болиоч, хасаач гээд л яриад байгаа юм л даа. Тэгээд түүн дээр яах вэ өчигдөр ч би бас хальт хэлчихсэн. 14 төсөл байгаад байгаа шүү дээ. Зураг, төсөвгүй гэдэг чинь нөгөө миний яриад байгаа 2 төсөл явж байгаа зураг, төсөвгүй гээд. Дээрээс нь магадлалгүй гээд. Тэгээд энэ ингээд өнгөрч байх шиг байна.

Дээрээс нь би нөгөө хиймэл дагуулыг асуумаар байгаа юм. 330 сая доллароор бид нар зээлээр хиймэл дагуул хөөргөх гэж байна шүү дээ. 1 аравны хэдэн их наяд болж байна энэ чинь бага мөнгө огт биш шүү дээ. Тэгээд энэний 25 хувь нь хөнгөлөлттэй зээл, 75 хувь нь арилжааны банкнаас авч байгаа зээл юм байна лээ шүү дээ. Тэгээд эргээд ингээд харахаар би хэдийн нэг баахан техникийн юм уг нь асуусан юм. Тэгээд энэ сайд нь байгаа юм уу, байхгүй юм уу, хэнээс ч асуух ёстой юм бүр гайхаад л байна л даа. Энэ чинь би ч бас мэргэжлийн 2, 3 хүмүүстэй холбогдоод л утсаар яриад л, уулзаад л ингэсэн тодорхой хэмжээнд яг ямар ач холбогдолтой, яг энэ ямар үүрэг функцтэй юм бэ гэдгийг нь зөндөө аминдаа битүүхэндээ судалсан.

Тэгэхээр энэ хиймэл дагуул маань broadcasting буюу телевиз, телевизийн үйлчилгээ бол байхгүй. Тэр өөр бас бус GPS энэ тэр бол тэртээ тэргүй байхгүй, зураг авах тагнуулын үйл ажиллагаатай холбоотой судалгааны юм байхгүй гээд. Ганцхан зорилго нь бол интернэт гэж би бол маш олон мэргэжлийн хүмүүсээс бол сонссон. Дахиад интернэт гээд тэгэхээр энэ бид нарт юу гэж ойлгуулж байна гэвэл энэ малчдыгаа ерөөсөө ямар ч асуудалгүйгээр интернэттэй холбох гэдэг нэг ийм зорилго яриад байгаа. Онцгой гэж яриад байгаа. Тэр онцгой байдлын үүргийг бол гүйцэтгэж чадахгүй гэж шулуухан хэлж байна лээ мэргэжлийн хүмүүс. Интернэтийг бол болно, гэхдээ айл болгон гадаанаа 150-аас 70см-ийн тийм хэмжээтэй антен байршуулна гэж байгаа юм. Тэгээд тэр антен нь дахиад зүгээр нэг тавьчих биш, яг тэр сансрын 36 мянган км-т байгаа тэр хиймэл дагуул руу харуулж ингэж тохиргоо хийгдэнэ гэж байгаа юм жишээлбэл.

Тэгэхээр энэ малчид ингээд энэ антenuудыг өөрснөө худалдаж авах юм уу эсхүл малчдад үнэгүй тараах гээд байгаа юм уу? Тэгэхээр энэ хөлс мөнгө нь хаана яаж тусгагдах юм бэ, хэдэн төгрөг гарсан юм бэ? Дээрээс нь тэр сар болгоны төлбөрийг нь хэн даах юм бэ гээд зөвхөн интернэтийнх нь асуудал гэхэд ингээд цаанаа зөндөө асуудал байгаа. Тэгээд энэ интернэт хангаад өнөөдрийг хүрчихсэн энэ хувийн хэвшлүүдийгээ яах гэж байгаа юм бол? Тэд нарт ажилладаггүй болгох гэж байгаа юм уу эсвэл тэд нар тэр байгуулчихсан гэрээгээ түрээс цуцлаад, энэ барих гэж байгаа, байршуулах гэж байгаа хиймэл дагуулаас интернэт авах юм уу гээд энэ чинь аягүй олон асуудал. Нөгөө шилэн кабель чинь хэрэггүй болох юм уу гээд асар олон асуулт дагуулсан асуудал байгаа юм байна лээ.

Мэдээж бодлогын хувьд бол Үндэсний аюулгүй байдал гэдэг талаас нь бол би ойлгож байгаа, дэмжиж байгаа. Гэхдээ үндэсний аюулгүй байдал талаас нь яг энэ үүргийг нь хэрэгжүүлэхийг бүрэн боломжтой 70 саяын өртөг бүхий хиймэл дагуулыг хөөргөж болно гээд бас энэ мэргэжлийн хүмүүс чинь яриад байна шүү дээ. Яг үндэсний аюулгүй байдал гэвэл. Интернэтийг бол ерөөсөө энэ бол ямар ч утгагүй зүйл юм байна. Малчид энийг авахгүй байх бүрэн эрхтэй. Тэгэхээр малчид хэн хэрэглэх юм бэ? Яг энэ Францын компаниас Бангладеш улс бол авсан. 2018 онд байхаа авсан юм байна лээ. Тэгээд тэр нь ямар ч үр ашиггүй бүүр дампуураад бөөн skandal үүсээд, дахиад 18 онд билүү, 19 онд авах гэж байхыг нь болиулсан байгаа байхгүй юу. Яг энэ Францын компаниас. Тэгэхээр нэг ёсондоо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хиймэл дагуул, Жудагийн Баярмаа гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Баярмаа: Тэгээд та нар зүгээр энэ нөгөө chat GPT-ээс асуухад л аягүй олон хувилбарууд гаргаж өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар чинь ямар олон асуудалтай байгаа билээ, зөндөө л ярьж байна. Тэгээд тэр бүгд асуудлаа шийдсэний ар дээр магадгүй илүү гараад байгаа мөнгө байгаа бол хэрэглэж болох юм. Гэхдээ энэ чинь дахиад зээл шүү дээ. Арилжааны банкнаас хэдэн хувийн хүүтэй зээл авч байгааг хэн ч мэдэхгүй. Би

мэдээлэл өгөөч гээд албан тоот явуулсан боловч надад огт мэдээлэл ирээгүй. Мэдээлэл ирээгүй учир би асууж сураглахаас өөр замгүй болоод байгаа юм. Тэгээд ер нь 69-ний, 69 машиныг л land cruiser 600-гийн үнээр авах гээд байгаа юм байна лээ шүү дээ. Одоо 69 унаж байгаа хүн байхгүй шүү дээ. Гэтэл үнэ нь land 600-гийн үнэ. Ингэж болох юм уу? Энэ чинь эргээд татвар төлөгчид л энэ зээлийг чинь төлнө шүү дээ. Энэ чинь зээл шүү дээ. Тэгэхээр ийм мөнгөн дүнтэй 1 гаруй их наяд төгрөгийн зээл авч, зөвхөн ингэж интернэтээр хангана гээд, тэгээд дээрээс нь тэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Баатархүү сайд байдаггүй. ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учралын энэ төслийн ажлын хэсгийн ахлагч бас орж ирээгүй байдаг. Яг хиймэл дагуултай холбоотой, хиймэл дагуулын төслийн асуудал бол Баярмаа гишүүн Улсын Их Хурлаар орж ирж нэг бүрчлэн яригдаж байж батлагдах төсөл шүү дээ. Түүнээс өнөөдөр бид энэ төсөв дээр тодорхой Монголын талаас Монголын ЗГ-аас хамаарах ёстой төсөв гэж суулгасныг энэ төсөл хэрэгжихээр болчихлоо, эцэслээд шийдчихлээ гэж үзэхэд учир дутагдалтай. Тэгэхээр энэ төсөл, энэ хиймэл дагуул нь өөрөө чанар стандартын хувьд ямар түвшнийх юм, дэлхийн зах зээлтэй харьцуулахад үнэ ханш нь яг ямар юм, бодитой эх сурвалжуудаас мэдээллүүдийг авч, Улсын Их Хурал дээр албан ёсны ажлын хэсэг байгуулагдаж байж энэ асуудал нэг мөр шийдэгдэх учиртай.

Ер нь бол технологи тэр чигтээ дижитал болж байгаа. Таны саяын яриан дунд бас зарим төрлийн аналог системүүдийн талын мэдээллүүд яригдаад байна. Тэгэхээр мэдээллээ нэлээн сайн бүгдээрээ нягтлаад, Улсын Их Хурлын гишүүд нэгд нэгэнгүй ижил мэдээлэлтэй болсны үндсэн дээр энэ хиймэл дагуулын төслийг явуулах эсэх, явууллаа гэхэд хаанахтай хамтарч ажиллах эсэх асуудлууд нэг бүрчлэн яригдана гэдгийг бас та бүхэндээ албан ёсоор ойлгуулъя.

Ер нь Улсын Их Хурлаар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт орж ирсэн 14 мега төсөл бүгдээрээ Улсын Их Хурлаар нэг бүрчлэн яригдаж, албан ёсны ажлын хэсгийн гаргаж байгаа санал, дүгнэлтийг Улсын Их Хурал дэмжсэн тохиолдолд асуудал цаашаагаа хэрэгжинэ. Энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байгаа гэдгийг бас хэлье. Ингээд 2025-аас 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байна. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой Баярмаа гишүүний бусад асуусан асуултад хариулах хүн байна уу? Алга байна. Даваасүрэн гишүүн Төсвийн байнгын хорооны дарга.

Ц.Даваасүрэн: Тэгэхдээ юу Баярмаа гишүүнээ яг энэ яг дэгээрээ бол яг энэ хэлэлцэж байгаа асуудал нь төсвийн хүрээний мэдэгдэл болчихоод байгаа юм. Түрүүний Төсвийн хуулийн санал хураалт явахад л уг нь нэлээн тодорхой наадхыг чинь ярих ёстой байсан байх. Зүгээр нэг ийм зүйлийг бас өөрөө хэрэглэж болно. Наад асуудлыг чинь ингээд яривал нэлээн өөрийн чинь хөндөж байгаа энэ сэдвээс харах юм бол углууртай яримаар байгаа байхгүй юу. Зүгээр 3, 4-хөн минутын дотор танд би хариулсан болдог ч юм уу, аль эсвэл нэг сайд хариулсан болоод өнгөрөх биш. Тийм учраас би зүгээр зөвлөхөд наадах асуудлаараа асуулга тавьчих. Тэгээд энэ хэдүүлээ нэг эхний хэлэлцүүлгээ бас хийе. Тэгээд дараа нь бас энэ төслийн асуудал би орж ирэх юм байна гэж бодлоо. Тэгж тодорхой ярихгүй бол яг энэ нэг төсвийн хэлэлцүүлгийн 3, 4-хөн минутад бол ярих асуудал бас биш юм шиг байна лээ. Би тэгээд би энэ хэлэлцүүлгийн явцад бол харж байхад би тэгж зөвлөмөөр байна.

Одоо гэхэд 2 сайд нь байхгүй. Байлаа ч гэсэн яг чиний яг тэр хэлээд байгаа шиг одоо ингээд ашиглалтын зардал малчин төлөх юм уу, үгүй юү, өөрийн чинь асуугаад байгаа зөв л дөө. Хамгийн өндөр зардал нь магадгүй ашиглалтын зардал болчихож магадгүй юм байгаа юм. Бид нар Starlink тэгж байгаа шүү дээ, сарын 200-г төлж байна уу,

үгүй юу яг ашиглаж байгаа үедээ. Түүн шиг төлбөрүүд нь ямар байх юм энэ тэр гээд тодруулах зүйлүүд төсвөөс өөр шинж чанартай ийм асуултууд гараад байгаа учраас тэгж шийдвэл яасан юм бэ гэж. Наадах дүн чинь бол одоо наана чинь орчихсон байгаа юу нь бол байна шүү дээ яг энэ төсвийн хүрээний мэдэгдэлд нөлөөлөх ийм баланст нөлөөлөх юм бол байхгүй. Яг өмнө нь бид нар нөгөө төсвийн тодотгол дээр нөгөө дүнг нь тавиад батлаад өгчихсөн байхгүй юу. Төсвийн тодотголоор шийдчихсэн байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Бид нар чинь төсвийн хүрээний мэдэгдлээ ярьж байгаа шүү дээ төсвийн төсөөллөө. Гэтэл яг саяхан хоёр дахь хэлэлцүүлгийг нь хийсэн төсөвтэй холбоотой асуудлуудаа яримааргүй байгаа юм. Жил болгон л ингээд л төсвийн мэдэгдэл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл ярьдаг юм. Тэгээд Жавхлан сайдаас ер нь өмнөх та бүхэн, та ингээд Сангийн сайдаар бараг 4, 5 жил ажиллалаа. Өмнөх он жилүүдийн та бүхний таны доор байгаа Сангийн яамны мэргэжилтнүүдийн чинь гаргасан жил болгоны энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл чинь яг таарсан нь хэр байгаа юм бэ, хэр бодитой төсөөлж байгаа юм бэ? Гадаад, дотоод зах зээл, улс төрийн нөхцөл байдал, бараа, бүтээгдэхүүний үнэ ханш, та бүхний хийж байгаа аргачлал юмнууд ер нь ямар аргачлалаар хийж байна вэ? Таарчихсан нь яг амьдрал дээр бодитоор ямар байна вэ? Энэ нэг хэдэн 9 үзүүлэлтээр л хийдэг байх. Энэ үзүүлэлтүүдийн чинь нийцэл нь?

Хэрвээ буруу төсөөлсөн бол, буруу таамагласан бол ер нь яадаг юм бэ, ямар хариуцлага хүлээдэг юм бэ? Эдийн засгийн яам уу тийм ээ? Тийм учраас би бас энэ өнгөрсөн хугацаанд энэ хийсэн жил болгоны хийдэг энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн талаар энэ холбогдох яамнаас нь асуумаар байна. Тэгээд бид нар ер нь бид нарт л баримжаа өгөх гэж байгаа л гэж ойлгож байгаа шүү дээ. Ер нь ирэх жил иймэрхүү байх нь, 2 жилийн дараа ийм нөхцөл байдал эдийн засаг ийм байх нь баримжаа л өгч байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд бид нар хэр нуруутай, голтой эдийн засгийн мэдээллээр хангагдаж явдаг юм бэ, таарц, нийцэл нь ямар байгаа юм бэ гэдгийг Гантөмөр сайд хариулах юм болов уу.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Гишүүний асуултад хариулъя. Ер нь төсөөлөл дээрээ нэг их айхтар алдаад байсан юм бол байдаггүй юм билээ. Тэр жил 2008 онд нэг айхтар хямрал болсон дэлхий дахинд. Тэр үед айхтар алдаанууд гарсан. 2016 онд валютын ханш нэг айхтар хөдөлсөн. Ялангуяа 17 онд санагдаж байна, бараг 2 дахин нэмэгдээд явчихсан. Тэр үед бол төсөөллүүд асар их алдагдсан. Түүнээс бусад үеэр нэг айхтар алдаа байхгүй. Тэгээд энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэл бол өнгөрсөн ээлжит бус чуулганаар бид нар Тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулсан. Тэр хүрээндээ төсвийн тодотголоо хийсэн. Тэр Тогтвортой байдлын тухай хуульд орсон өөрчлөлтөө дагасан өөрчлөлтүүд л орж ирж байгаа гэж ойлгож болно.

Өнгөрсөн жилийн биш, 2024 оны 5 сард Төсвийн хүрээний мэдэгдэл баталчихсан байгаа юм 24 оны, 25 оны төсвийн хүрээний мэдэгдлийг Их Хурал баталчихсан. Тэр үед төсөөлж байсан эдийн засгийн өсөлт бол хөдлөөгүй. Хэрэглээний үнийн индекс буюу инфляцаа 0,5 хувиар нэмэгдүүлж байгаа. Бид нар өнгөрсөн энэ жилийн сонгууль болохоос өмнө эдийн засгаа төсөөлж байсан байна шүү дээ. Тэр төсөөллөөр 25 онд эдийн засаг 8

хувь өснө гэсэн ийм төсөөлөлтэй байсан. Энэ төсөөллөө энэ удаагийн хуулиараа ч гэсэн энэ тоо бол хөдлөөгүй.

Нөгөө талдаа инфляц байдаг. Инфляц 6 хувь байна гэж, 6,5 билүү. Төсвийн хүрээний мэдэгдэлд батлагдчихсан тоо бол тийм байсан. Энэ удаа бол 1,5 функтээр нэмэгдэж байгаа юм. Яагаад 1,5 функтээр нэмэгдсэн бэ гэхээр ер нь бол энэ эрчим хүчний үнэ бол хөдлөх юм байна, дулааны үнэ хөдлөх юм байна. Энэ эрчим хүчний үнэ, дулааны үнэ бол өргөн хэрэглээний бараа дээрээ 1,5 хувийн өсөлтийг дагуулах юм байна гэж ингэж орж ирж байгаа.

Төсвийн орлого яагаад нэмэгдчихэв гэдэг асуудал байгаа. Төсвийн орлого 3 хүчин зүйлээс хамаарч нэмэгдэж орж ирж байгаа. Тэр нь юу вэ гэхээр 1 дүгээрт энэ Тусгай сангийн хуульдаа бид нар өөрчлөлт оруулаад Баялгийн сан руу очих мөнгөнөөсөө тодорхой хэмжээний мөнгийг төсөв рүүгээ татаж авч байгаа 1 дүгээрт. 2 дугаарт ирэх жил явах бүтээн байгуулалттай холбоотой тодорхой төлөвлөлтүүдээсээ нэмэгдэж орж ирж байгаа. Ингээд бусдаараа ерөнхийдөө энэ төлөвлөлт чинь ингээд хөдөлгөөнгүй яваад байгаа юм байна лээ шүү гэдгийг бүгдээрээ ойлгох хэрэгтэй. Тогтвортой байдлын хуульдаа хэдүүлээ ямар өөрчлөлт оруулснаа бол бүгдээрээ мэдэж байгаа. Түүнээс биш Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яам болоод бусад институтүүд ямар нэгэн байдлаар энэ тооцоо дээр алдаа их бага.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна, алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна, алга байна. Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

Д.Батбаяр: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд сэдвийнхээ хүрээнд ярина гэхээр чинь энэ чинь уг нь ер нь өдийд бид нар энэ тухай ярьж байх ёсгүй шүү дээ 5 сард л аль хэдийн баталчихсан, тэрэндээ тааруулаад төсвөө хийж байх ёстой байсан сэдэв шүү дээ. Тийм учраас өргөн хүрээтэй болчхож байгаа, нэгэнт ороод ирчхэж байгаа учраас төсөвтэй холбоотой зүйлийг асуух нь буруу зүйл биш байх гэж бодож байна.

Тэгээд би энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдаас уг нь юм асууя гэж бодсон юм. Яах вэ даргаа? Дараагийнхаа асуултуудыг нь асуугаад явж байх уу сайд нар нь байдаггүй.

Д.Амарбаясгалан: Төсвийн төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа. Би түүрүүн ажлын хэсгийг танилцуулсан. Сайд нараас Сангийн сайд Болдын Жавхлан албан ёсоор байгаа төсвийн хүрээний мэдэгдэл учраас. Бусад сайд нар заавал байлцах үүрэг хүлээгээгүй байгаа. Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд байж байгаа.

Д.Батбаяр: Байгаа сайд нараас нь тэгвэл асуугаад явчихъя. Сая манай АН-ын бүлэг дээр бас орж ирсэн энэ нөгөө Эрчим хүчний шинэчлэлийн хорооноос ирж танилцуулга хийсэн. Тэгээд энэ дээр үндсэн арга нь энэ эрчим хүчний дулааны халаалтын үнийг нэмэх л болчхоод байгаа юм л даа. Тэгээд энэ дээр нэг ийм асуудал босож ирж байгаа. Дараа жил чухам босож ирэх юм уу, дахиад тодотгол гэж орж ирэх юм уу? Энэ хүрээтэй чухам яаж өөрчлөлт нөлөөлөх юм бол гэдэг асуудал. Тэр юу вэ гэхээр энэ хувийн хэвшлийнхний дэмжих талаар ер нь энэ бодлого байж болохгүй юм уу? Энэ талаар та хэд минь яагаад хамтарч ажиллаагүй юм бэ? Тэр нь жишээлбэл татварын хөнгөлөлт ч байдаг юм уу, төлбөрийн хойшлуулалт ч байдаг юм уу иймэрхүү байдлаар хувийн хэвшлийгээ яг энэ

эрчим хүчний үнийн нэмэлтэй холбоотойгоор ямар нэгэн байдлаар хамгаалах ийм хөтөлбөрт орж болоогүй юм уу гэдэг асуулт байна 1 дүгээрт нь.

2 дугаарт нь иргэдийн хувьд ялгаа байхгүй. Иргэдийн яг энэ бага оврын нарны станц ч байдаг юм уу энийг авахад нь НӨАТ-ынх нь татвараар, гаалийн татвараар нь хөнгөлөх ийм боломж байгаагүй юу, ийм бодлогыг ер нь баримтлах боломж байсан уу? Энийг 25 онд нь нөхөж оруулах боломж байгаа юу? Яг энэ Шинэчлэлийн хорооноос өгсөн мэдээллээр яг энэтэй холбоотой мэдээлэл өгөөгүй учраас би тодруулж асууж байгаа юм.

2 дугаарт нь Боловсролын сайдаас асуух асуулт байна. Энэ дээр нийтдээ сая хэлж байна 90 сургууль, 62 цэцэрлэг буюу ойролцоогоор 4 мянга орчим ажлын байр бий болох юм байна л даа. Яг жинхэнэ төсөв яагаад жилээс жилд томроод байдаг вэ гэдгийн жинхэнэ сонгодог яг жишээ нь энэ байхгүй юу. Жишээ нь бол энэ Хөвсгөл аймгийн Тариалан суманд 960 хүүхдийн цэцэрлэг, сургууль 4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байж байснаа 11,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй болчихсон байгаа байхгүй юу. Тэр янз янзын тэр магадлалтай холбоотой асуудлуудыг нь бол Байнгын хороон дээр нь асуугаад, асуугаад хариулт авч чадаагүй.

Тэгэхээр би танаас юу гэж асуух гээд байна вэ гэхээр та сая энэ өнгөрсөн хугацаанд сайд хийж байх хугацаандаа энэ боловсон хүчин бэлтгэх асуудал дээр нэлээн асуудалд ороод нийгэмд анхаарал татаад байсан. Тэгэхээр яг энэ шинээр бий болж байгаа сургууль, цэцэрлэгийнхээ боловсон хүчнийхээ асуудлуудыг шийдэх тал дээр ер нь ямар бодлого баримтлаад байгаа вэ? Хэдэн ажлын байр нэмэгдэж байгаа вэ? Түүн дээр нь энэ цалин болон энэ урсгал зардал энэ тэр дээр нь ямар бодлого баримтлах юм бэ? Энийг энэ төсөвтэйгөө холбож оруулж ирсэн юм уу, хамтарч ажилласан юм уу гэдэг ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яамны Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Хэдүүлээ дөнгөж сонгуулийн дараа төсөв төлөвлөгөөгөө ярьж байгаа учраас зарим нэг бичиг баримтууд урд, хойноо ороод байгаа гэдгийг цөмөөрөө ойлгож байгаа байх гэж би хувьдаа бодож байна. Түүнээс биш энэ сонгууль болоогүй байсан бол яг тогтвортой тухайн цаг хугацаандаа тухайн бодлогуудынхаа баримт бичгийг батлаад явах байсан байх. Тийм учраас түүрүүн Их Хурлын дарга хэллээ. Ирэх 5 сард хөгжлийн төлөвлөгөөгөө яс хийнэ хэдүүлээ. Төсвийн хүрээний мэдэгдлээ ч гэсэн батална. Тэр хүрээндээ 9 сарын 1-нд юмаа оруулж ирээрэй.

Тэгэхээр одоо бол манай гишүүд юунд анхаарах ёстой вэ гэхээр 5 сарын 1 хүртэл төсвийн энэ шинэчлэл гэдэг зүйлийг яаж хийх юм бэ гэдэг дээрээ тал талаасаа хүчээ нийлүүлээд ажиллах хэрэгтэй. Ингэж чадах юм бол бид нар магадгүй ирэх оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 26 оныхоо мэдэгдлийг батлахдаа төсөөллийнхөө дагуу байх уу, түүнээсээ илүү эрүүлжсэн, шүүмжлэл дагуулахгүйгээр батлах уу гэдгээс шалтгаалаад бид нарын төсөв хэлэлцэх үеийн нөхцөл байдал их өөр болно шүү. Тийм учраас хэдүүлээ энэ 5 сарын төлөвлөлт дээрээ, 6 сард батлагдах төлөвлөлт дээрээ онцгой анхаарч 1 дүгээрт ажиллах хэрэгтэй.

2 дугаарт ер нь энэ ЗГ бол 2 зүйлийг л хэлээд байгаа шүү дээ. 1 дүгээрт энэ хөгжлийн садаа болоод өнөөдөр хүртэл шийдэгдээгүй олон ажлууд байна. Энийгээ бид нар 14 мега төсөл гэж нэрлэж байгаа. Энэ ажлуудынхаа ард гаръя гэж байгаа юм. Ингэж чадах юм бол Монгол Улсын эдийн засгийн эрсдэл алга болох юм гэж 1.

2 дугаарт эдийн засгийн орчноо сайжруулъя. Бизнесийн орчныг эрүүл болгоё гэдэг ийм зорилт дэвшүүлж байгаа юм. Бизнесийн орчин эрүүл болохгүйгээр Монгол Улсын эдийн засаг төрөлжих, нөгөө талдаа Монголын эдийн засгийн дотоод эргэлт сайжрах гэдэг зүйл бол байхгүй. Тийм учраас ЗГ-ын 2 дахь том зорилт бол бизнесийн орчныг эрүүлжүүлэх, хувийн хэвшлээ дэмжих гэдэг дээр манай гишүүд бас онцгой анхаарч ажиллах шаардлага байна.

3 дугаарт эрчим хүчний реформ яриад байгаа юм. Энэ дээр магадгүй компаниудад хүндээр тусах зүйл гарч магадгүй. Тэгэхдээ нөгөө талдаа нэг зүйл байгаа. Үйлдвэрлэл болоод бусад салбарыг хөгжүүлбэ гэвэл эдийн засгийн юу эрчим хүчний байгаа орчныг сайжруулахаас өөр аргагүй байна. Өнөөдрийн байгаа нөхцөл байдал цаашаагаа үргэлжлэх юм бол магадгүй Монгол Улсын эдийн засаг өсөх биш унахаар байна. Үйлдвэрлэл нэмэгдэх биш хасагдахаар байна. Сүүлдээ зөвхөн танил талтай хүмүүс нь дулаан авдаг, танил талтай хүмүүс нь эрчим хүч авдаг ийм улс орон болж хувирах аюул байгаа учраас бид нар энэ эрчим хүчний реформыг зайлшгүй хийнэ. Хийхдээ эхний ээлжид яг орлого багатай айлууд дээрээ бид нар дэмжлэг үзүүлнэ. Тийм учраас төсөв дээр тэр 50 тэрбум төгрөг тавьчихаад байгаа шүү дээ. Дараа нь хувийн ААН-үүд дээрээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ сургууль, цэцэрлэгийн барилгуудыг нэг амсуулах замаар оруулж ирчхээд тэгээд 5, 6 жил он дамнуулж, тэр хооронд нь барилгын магадлан үнэлгээгээр оруулж, үнийг нь хэд дахин нэмдэг ийм нэг хачин систем яваад ингээд их ужгирсан ийм байдалтай байгаад байгаа юм. Энийг бол бид нар энэ удаагийн төсвөөр бол нэлээн сайн засаж чадсан гэж ингэж бодож байгаа. Цаашдаа ч энийгээ засаад явах болно. Ер нь бол хиймэл оюун ухаанд суурилсан газрын зураг дээр хүн амынх нь нягтаршилтай холбоотойгоор сургууль, цэцэрлэгийнхээ барилгыг ингэж шийддэг ийм систем рүү орж байгаа гэдгийг танд дуулгая.

Харин энэ багшлах боловсон хүчний тал дээр бол энэ жил гэхэд боловсролын салбарын төрийн албан хаагч гэхэд 93667 хүн байгаа байхгүй юу. Тэгээд цалингийн өсөлт нь ноднин бол 2,1 их наяд байсан бол энэ жил 2,4 их наяд болж ингэж өсөж байгаа юм. Тэгэхээр зэрэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Батбаяр гишүүн асуусан тэр эрчим хүчтэй холбоотой ер нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд байгаа юу гээд. Ерөнхийгөөрөө бол одоо бид орж ирж байгаа шүү дээ, салбар харгалзахгүйгээр боловсруулах шатны гэдэг нь энэ дээр ороод л явчихна эрчим хүчний үйлдвэрлэл гаргах, дэд бүтцийг суурилуулах, суурилагдсан эрчим хүчний үйлдвэрлэл эх үүсвэрээ өргөтгөх ч гэдэг юм уу үүгээрээ бол ингээд гаалийн татвараас бүрэн чөлөөлнө гээд. Гэхдээ яг энэ эрчим хүчний салбарт бид сүүлийн жилүүдэд нэлээн хэд хэдэн яг тогтвортой ийм хөнгөлөлт, чөлөөлөлтүүд гарчихсан явж байгаа шүү.

Тухайлбал ингэж байгаа ААНОАТ-аар цахилгаан эрчим хүчний 5мвт-аас дээш эсхүл дулааны эрчим хүчний 1,5мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмжид, үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг 90 хувь хөнгөлнө гээд. Гаалийг нь ч хөнгөлчихсөн явж байгаа. Тийм учраас эдгээр хөнгөлөлтүүд маань ер нь яагаад үр дүн гарахгүй, энэ салбар луу хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа юм байна.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодруулга 1 минут Далайн Батбаяр гишүүнд өгье.

Д.Батбаяр: Баярлалаа. Яах вэ сая барилга угсралтын ч юм уу, энэ цахилгаан эрчим хүчний угсралтын жишээ дурдаад байх шиг байна л даа. Жишээлбэл энэ гараад харахад нэг гуанз ч байдаг юм уу, нэг хоолны газар ч юм уу тиймэрхүү энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн энэ байгууллагуудад ямар нэгэн бодит дэмжлэг байна уу л гэж би асуугаад байгаа байхгүй юу. Мөн иргэдэд ямар нэгэн бодит дэмжлэг байна уу?

Яагаад гэхээр түрүүн эрчим үнээ, Эдийн засгийн хөгжлийн сайдын дурдаад байгаа 56 тэрбум төгрөг бол төрийн төсвийн байгууллагуудад зориулагдсан 56 тэрбум байгаа байхгүй юу. Хамгийн их нь тэр нь Хууль зүйн сайдад, хууль зүйн салбарт хуваарилагдаж байх шиг байна лээ. Тэгэхээр яг энэ иргэд бол яг жижиг, дунд үйлдвэрлэл, жижиг дунд ч гэхгүй ер нь том үйлдвэрүүддээ л яг ийм бодит тусламж гэх үү тийм татварын хөнгөлөлт тиймэрхүү юм байгаа юу л гэж асуусан хэрэг. Тийм, эрчим хүчний үнэ нэмснээс болоод 2025 онд тодорхой хэмжээний шок үүсэх нь. Бизнесийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт 3 үзүүлэлттэй холбоотой асуулт асууя. 1 дүгээрт нь ДНБ-ий бодит өсөлтийг 8 хувиар өсгөхөөр тооцжээ. Тэгэхээр өмнө нь бид нар төсвийн тусгай шаардлагуудаасаа уул уурхайтай холбоотой хэсгээ аваад хаячихсан байгаа. Тэгэхээр энэ 2025 оны 8 хувийн өсөлт дотор уул уурхайн бус салбарууд ямар өсөлттэй байгаа вэ гэдэг нэг асуулт байна.

2 дугаарт хэрэглээний үнийн өсөлтийг 7,5-аар тооцсон байна. Тэгээд энэ дотор хамгийн өндөр өсөлттэй барааг хэдэн хувь өснө гэж тооцсон бэ?

Гуравдугаарх нь төсвийн нэгдсэн зарлагын дээд хэмжээг гэсэн 4 дүгээр үзүүлэлтийн талаар? Тэгэхээр энэ дээр 2025 онд орж ирсэн төсвөөр болохоор төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 37,7 хувиар, 26 онд 35,7 хувиар, 27 онд 34,3 хувь байхаар ийм дээд хязгааруудыг нь тогтоосон байна л даа, төсөөлсөн байна л даа. Тэгэхээр МАН, АН, ХҮН намын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 25 хувь хүртэл бууруулна, 20 хувь хүртэл бууруулна гэдэг заалтууд амлалтууд орсон байгаа. Тэгэхээр яах вэ энийг ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэх үед энийг жишээлбэл 4 жил байгаа юм чинь болно гэж ярьж байсан. Тэгэхдээ сая энэ төсөв дээр ч гэсэн ярихад бол дахиад 4 жил байгаа юм чинь бууруулна гэж байсан. Тэгэхээр эндээс харахаар 34,3-аас 2028 онд 25 хувь ч юм уу, ядаж 20 луу дөхөх, 30 руу дөхөх тийм боломж харагдахгүй харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр яаж төсөөлж байгаа вэ? Тэгэхээр энэ хэцүү зорилт юм биш үү? Эртнээс ингэж буулгаж явахгүй бол гэдэг ийм 3 асуулт байна.

Тэгээд 1 санал байгаа. Мөнхсоёл гишүүний түрүүн ярьж байсан энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөө бид нар Улсын Их Хурал энэ төсөвтэй холбоотой асуудал дээр мэргэжлийн ийм бие даасан бүтэц бий болгосон учраас энэ бүтцээ их сайн дэмжиж ажиллах ёстой гэж санагдаж байна. Тэгэхээр энэ ойлголцлыг сайжруулахын тулд тусад нь ингэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн танилцуулга хийж, илүү дэлгэрэнгүй асууж, ярьдаг ийм өөрчлөлтийг оруулах нь зүйтэй юм уу гэсэн ийм саналтай байна. 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Тийм ер нь 26 оны төсвийн хүрээ, төсвийн төсөөллийг ярихдаа та хэд Тогтвортой байдлын зөвлөлтэйгөө 1, 2 сар сайн ажиллаадах гэмээр байна Их Хурал. Тэгээд 3 сард нэг эргэлзээгүй тоотой бол. Тэгээд 3 сард эргэлзээгүй болсон тоогоо ЗГ-т чиглэл болгоод тогтоол гаргаад өгчих. Тэгээд бид нар 5 сард Их Хурлын хүсэж байгаа тоонуудыг оруулаад ирж болно. Ийм хамтын ажиллагаа хийхгүй бол нэг өдөр ЗГ тоо өргөн барьдаг, зэрэгцүүлээд олон байгууллагууд ингээд саналаа илэрхийлдэг байгаа байдлыг хүн болгон өөрөөр харж болно. Дэлхийн банк өөрөөр хардаг, Валютын сан өөрөөр хардаг, Азийн хөгжлийн банк өөрөөр хардаг юм. Энэ бол өөрсдийнх нь барьж явдаг хүчин зүйлээс их хамааралтай.

Ингэж чадах юм бид нар Хөгжлийн төлөвлөгөөгөө төсвийн хүрээний мэдэгдэлтэйгээ Их Хуралтайгаа, Тогтвортой байдлын зөвлөлтэйгөө нэг тоотой ороод ирж болно. Бид нар зөрүүдлээд байгаа юм ерөөсөө байхгүй. Энэ удаагийн Төсвийн хүрээний мэдэгдэл би түрүүн хэлсэн, хууль өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тоо бол хөдөлж байгаа. Тэгэхдээ үндсэн тоо. Таны асуудаг өсөлт бол хөдлөөгүй. Эдийн засгийн өсөлт бол яг төлөвлөсний дагуу орж ирсэн. Инфляц 1,5 хувиар нэмэгдэж байгаа. Энэ нь эрчим хүчний реформтой холбоотой. Энийг энд, тэнд нууж хаагаад байх юм байхгүй. Ийм тооцоолол гаргаж байгаа. Орлого дээр өсөлт бий болсон, зарлага дээр өсөлт бий болсон. Өсөхдөө тэнцвэржүүлсэн зарлагаа бид нар орлогоосоо бага 1,9 их наядын багаар авч байгаа. Нэг үгээр хэлбэл Монгол Улсын төсөв бол ашигтай батлагдаж байгаа. Ашигтай батлагдаж байгаа. Зээлийн гадаад зээлийн хэрэглээгээ нэмээд явъя гэж байгаа.

Ер нь бол энэ их тэлэлт Энхтүвшин гишүүнээ та хэд юманд эргэлзээд байгаа юм. Энэ их тэлэлтийн ард бол Улаанбаатар хотын түгжрэлийг шийдэхийн төлөө л байгаа. Бүгдээрээ нэг юмыг энэ тоонуудаа хараад ойлгоод авчих хэрэгтэй. 4,5 их наядын хөрөнгө оруулалтыг Улаанбаатар хотод хийж байгаа. Улаанбаатар хотын асуудлыг 20 жил шийдэхгүй бид нар хойшоо хаясан, одоо шийдье гэж байгаа. Тийм учраас хэдүүлээ юун дээр анхаарах вэ гэхээр Улаанбаатар хотын иргэдийн хурлаар орж батлагдах төсвийг бид анхаарах хэрэгтэй. Энэ Улаанбаатар хотод хэрэгжүүлж байгаа төслүүдийн явцад анхааралтай ажиглах хэрэгтэй. Энд бид мөнгө өгөөд байдаг, ажил тэнд явах ёстой гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талдаа тэр 8 хувийн өсөлт дотор аль, аль салбарыг нь хэдээр вэ гэдгийг би та, бид нар бол та бүхэнд тараасан ном дээр бүүр ингээд ширхэгчлээд гаргаад өгчихсөн шүү дээ. Тэгэхээр би бол уншина, өөр арга байхгүй. Жишээлбэл хөдөө аж ахуйн салбар бол 25 онд 6 аравны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд гүйцээж хариулья.

Л.Гантөмөр: Баярлалаа. Хөдөө аж ахуйн салбар ирэх онд 6,1 хувь өснө, уул уурхайн салбар 16,2 хувь өснө, боловсруулах салбар бол 9,6 хувь өснө, мөн цахилгаан, ус гээд энэ бол 7,3 хувь өсөх юм байна. Барилгын салбар 7,4 хувь өснө, худалдааны салбар бол 5,7 хувь өснө гэх мэтчилэн бид нар бол тооцооллоо хийсэн байгаа шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Нөгөө талдаа бид энэ уул уурхайн салбарын өсөлтөөс бусад салбарын өсөлтийг хийхийн тулд санхүүгийн зах зээлээ чөлөөлөх хэрэгтэй. Яалт ч байхгүй Монголд мөнгөний эргэлт зөвхөн банкаар яваад байна. Бирж гэдэг зүйл хөдлөхгүй байна. Арилжааны бүтээгдэхүүн алга байна. М2 өөрөө томрохгүй байгаа үндсэн шалтгаан бол мөнгөний эргэлт 1 аравны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя 1 минут.

Д.Энхтүвшин: Би нөгөө төсвийн зарлагатай холбоотой 4 дүгээр үзүүлэлтийг асуусан байгаа. 37 аравны төсвийн нийт зарлагын дээд хэмжээ ДНБ-д эзлэх хувь нь 37,7 25 онд, 26 онд 35,7, 34,3 гээд. Тэгэхээр энэ үзүүлэлтээс харахад МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр, АН-ын мөрийн хөтөлбөрт заасан 25 хувь, 20 хувь буулгана гэсэн үзүүлэлтэд хүрэхэд их ийм хэцүү зорилтыг 28 онд үлдээж байгаа юм биш үү? Үүгээрээ явбал энд хүрэх боломжгүй. Энэ сонгууль энэ амлалт сонгогчдыг хуурсан юм шиг ийм дүр зураг үзүүлээд байна л даа. Тэгэхээр энэ дээр өөрчлөлт хийх боломж байхгүй юу, энийг яаж харж байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Би түрүүн хэллээ шүү дээ. Хэдүүлээ 1 сар, 12 сар, 1 сар, 2 сарыг яг энэ төсвийн суурь зардлыг бууруулах чиглэлээр ажиллая, ажиллахгүй бол болохгүй. Сая бол үндсэндээ бид нар 9 сарын 1-нд төсөв өргөн барих гэдэг хугацаанд шахагдсан шүү. Бодит байдлаа хэлье. 8 сард бид нар тодотголоо баталсан шүү, бодит байдлаа хэлье. Тийм учраас бидэнд яг өнөөдөр ингээд хийчихсэн энд эрчимтэй шинэчлэл бол байхгүй. 25 оны хувьд бол байхгүй, урсгалаараа явж байгаа. 100км цаг гишгэчихсэн байхгүй юу даа Энхтүвшин гишүүнээ. Одоо бид нар гэнэт тоормослоод 30км цагийн хурд руу авчирья гэхээр энэ машин чинь онхолдчих гээд байна.

Тийм учраас бид нар 100км цагийн хурдтай явж байгаа машиныг 90 болгоод, 80 болгоод, 70 болгож явах төлөвлөлтийг 12, 1, 2 сард хийх хэрэгтэй, зайлшгүй хийх хэрэгтэй. Ингэж байж бид нарын хүсээд байгаа зардал нь ДНБ-дээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээс л би ганц асуулт байна л даа. Ер нь бид энэ түрүүнд Энхтүвшин гишүүн дурдаж байна. Нэгэнт Улсын Их Хурлын дэргэд 2 гол байгууллага байгаа. Аудит, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд. Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой дүгнэлт дээр ЗГ-ын нийт өрийн хэмжээ 23 оны төсвийн гүйцэтгэлээр 30,7 тэрбум, 24 оны төсвийн гүйцэтгэл хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 35,2 тэрбум, 25 оны төсөөллөөр дахиад 5,2 тэрбумаар нэмэгдэж, нийтдээ 40,4 тэрбум төгрөг болохоор төсөвлөсөн нь ДНБ-ий 42,6 хувь болж өсөх нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.8-д Төсвийн хүрээний мэдэгдэлд ЗГ-ын өрийн нийт хэмжээг тусгана гэсэн атал өргөн мэдүүлсэн төсөл ЗГ-ын нийт өрийн нийт хэмжээ дээд түвшнээр гэсэн нь хууль зөрчлөө гэсэн байна. Энэ ямар учиртай юм бэ гэж би Сангийн сайдаас энэ талаар асуулт асууж байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлтийг юу гэж ойлгох вэ?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Бид нар чинь төсвийн хүрээ ярьж байгаа шүү дээ. Төсвийн хүрээ бол яг хязгаар. Тэрнээс гүйцэтгэл бол өөрөөр гарч байгаа. Тухайлбал 23 оны гүйцэтгэлийг бид нар сарын өмнө баталсан. Өрийн дээд хязгаар Төсвийн хүрээний мэдэгдлээр 60 байгаа. Гүйцэтгэл бол 39 хувьтай гарсан байгаа. Хойтонгийнх жишээ нь 42,6-гаар нь. Гэсэн хэдий ч Төсвийн хүрээний мэдэгдлийн бид нар хуулиар байдаг 60-ыг бол төсвийн хүрээн дээр 55 гэж бууруулж оруулж ирж байгаа шүү

дээ. 55 байсан ч гүйцэтгэл нь 43 дотор гараад, цаана нь дахиад ингээд 12 хувийн нөөцтэй явж байгаа гэсэн үг.

Хэтэрсэн гэж та алийг хэлээд байна вэ? Тийм, төсвийн хүрээ гэдэг бол дандаа хязгаарууд шүү. Эндээс хальж болохгүй гэдэг. Гүйцэтгэлийг бид мөн сая энэ төсвөөрөө ингээд батлуулаад авч байгаа. Тэгэхээр хойтон бол гүйцэтгэл 42,6 хувь дотроо л гарна, хэтрэхгүй, юун 60 битгий хэл 42,6 гарна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас бүлэг болон бүлэггүй Улсын Их Хурал, бүлэгт харьяалагддаггүй Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлэх боломжгүй юм байна дэгийн дагуу. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

16.04 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Чуулганыхаа хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд талархал дэвшүүлье. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл 16 цагаас Улсын Их Хурлын даргын өрөөнд хуралдана.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.УЯНГА